

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН АЖЛЫН АЛБАНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024.12.17

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Хувь
Стратегийн зорилт №1. Цөмийн энергийн салбарын бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох;							
1.1.	Цөмийн энергийн комиссын хуралдааныг зохион байгуулах, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулна.	Үйл ажиллагааны зардал	- Төлөвлөгөө батлагдсан эсэх; - Төлөвлөгөөний хэрэгжилт /хувиар/;	- ЦЭК нь 2023 онд салбарын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар нийт 3 удаа хуралдаж, 19 асуудал хэлэлцэж, 7 тогтоол гарсан.	- Цөмийн энергийн салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах хүрээнд Засгийн газрын хуралдаанд салбартай холбоотой асуудлуудыг хэлэлцүүлж, Цөмийн энергийн комиссын хуралдааныг зохион байгуулна. - ЦЭК-ын хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. - ЦЭК-ын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлийн хуралдааныг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна. - ЦЭК-ын Цацрагийн аюулгүйн зөвлөлийн хуралдааныг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна.	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 1/16 дугаартай албан бичгээр БШУЯ-нд хүргүүлсэн. Төлөвлөгөөнд тусгагдсан дараах асуудлуудыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. Үүнд: 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар "Цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг Монгол Улсад ашиглах суурь судалгааг эхлүүлж, цаашид баримтлах бодлогын чиглэл санал боловсруулах Ажлын хэсгийн тайлангийн талаар танилцуулсан. ОУАЭА-ийн зөвлөмжийн дагуу Цөмийн эрчим хүчний станцын дэд бүтцийн үндсэн 19 асуудлыг судалж, урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан танилцуулахыг БШУ-ны Сайд, ЦЭК-ын дарга Л.Энх-Амгаланд даалгасан Засгийн газрын 13 дугаар хуралдааны тэмдэглэл гарсан. 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар ЦЭК-ын 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулсан. Монгол Улсын Засгийн газарт "Гурвансайхан" ХХК-ийн хөрөнгө оруулагч Бүгд найрамдах Чех улсын "Ураниум индустри" компаниас ирүүлсэн арбитрын мэдэгдэлд дурдсан асуудлыг судалж санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллаж холбогдох санал дүгнэлтийг өгч тус асуудлыг Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанд ажлын хэсгийн хамт танилцуулсан. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулан Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 10 дугаар сарын 25-ны өдөр УИХ-д өргөн баригдсан. 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол,	75

					Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн. - Монгол Улсын Засгийн газар, Орано Майнинг компанийн хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулах, хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын дэд хэсэгт ажиллаж, холбогдох санал дүгнэлт, танилцуулга мэдээлэл өгсөн. - Комиссын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр БШУ-ны сайд, ЦЭК-ын дарга Л.Энх-Амгалангаар батлуулсан. - ЦЭК-ын хуралдааныг 2 удаа зохион байгуулж, нийт 11 асуудал хэлэлцүүлж, 3 тогтоол гарсан. Үүнд: 1. ЦЭК-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан; 2. ЦЭК-ын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан; 3. ЦЭК-ын дэргэдэх Цацрагийн аюулгүйн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан; 4. ОХУ-ын Дубна хот дахь Цөмийн шинжилгээний нэгдсэн институтын Монгол Улсын төлөх татварын талаар; 5. “Цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт материалыг хадгалалтад хүлээн авах, хүлээлгэн өгөх журам”-ын төсөл; 6. “Байгалийн гаралтай цацраг идэвхт материалтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн мониторинг хийх журам”-ын төсөл; 7. “Гурван сайхан” ХХК дахь төрийн хувь эзэмшлийг нэмэгдүүлэх тухай; 8. Цөмийн эрчим хүчний чиглэлээр хийгдэж буй ажлын тухай; 9. Цөмийн технологийн төсөл, хөтөлбөрийн тухай; 10. Цөмийн энергийн тухай хуулийн 15.3-т заасан зөвшөөрөл олгоход санал өгсөн талаар; 11. Цөмийн энергийн салбарын танилцуулга; - ЦЭК-ын тогтоол, хуралдааны тэмдэглэлийг албажуулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн.
--	--	--	--	--	--

						- “ЦШНИ-д төлөх Монгол Улсын гишүүнчлэлийн татварын талаар” 2024 оны 01 дүгээр тогтоол; - “Журам батлах тухай” 2024 оны 02 дугаар тогтоол; - “Төрийн эзэмшлийн хувьцааг нэмэгдүүлэх тухай” 2024 оны 03 дугаар тогтоол; ЦЭК-ын хуралдаанаар хэлэлцэх 11 асуудалтай холбоотой танилцуулга мэдээлэл, дүрэм журам, шийдвэрийн төсөл зэрэг баримт бичгүүдийн төслийг боловсруулж, комиссын дарга, гишүүдэд албан бичгээр болон цахимаар хүргүүлсэн. ЦЭК-ын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлийн 2024 оны хурлын төлөвлөгөөг батлуулж, зөвлөлийн хурлыг тайлант хугацаанд 1 удаа зохион байгуулсан. “ОУАЭА-ийн ТХА-ны хөтөлбөрийн хүрээнд 2026-2027 онд хэрэгжүүлэх төслүүд”-ийн талаар хэлэлцүүлэн, 2024/01 дугаартай зөвлөмж гаргуулсан. ЦЭК-ын дэргэдэх Цацрагийн аюулгүйн зөвлөлийн хуралдааныг 1 удаа зохион байгуулж, дараах 3 асуудлыг хэлэлцүүлэн, 2 зөвлөмж гаргасан. Үүнд: - ОУАЭА-ийн Зөрчил, хууль бус хөдөлгөөний мэдээллийн санд бүртгүүлэхээр төлөвлөж буй зөрчлийн мэдээллүүдийн тухай; - Цацрагтай ажиллагчдын ажил, мэргэжлийг “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох хөдөлмөрийн хортой нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д тусгуулах тухай; - “Дулааны цахилгаан станцуудаас гарах хаягдал үнсний цацрагийн үзүүлэлтийг тодорхойлж, барилгын материалд ашиглах тухай”.	
1.2.	Олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн орох бэлтгэл ажлыг хангана.	Үйл ажиллагааны зардал	- Шинээр нэгдэн орсон гэрээ, конвенцийн тоо;	- Улсын Их Хурлын 60 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны нэгдсэн конвенцод нэгдэн орох тухай асуудлыг хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой	- Монгол Улсын цөмийн аюулгүй байдалд чухал ач холбогдол бүхий олон улсын 4 конвенц, протоколд нэгдэн орох ажлыг зохион байгуулна: 1. Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц; 2. Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц 3. Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны	- Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа хийсэн. - Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц,	100

				зөвшилцөхөөр шийдвэрлэсэн бөгөөд Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар уг конвенцод нэгдэн орох асуудлыг зөвшилцөж дэмжсэн.	конвенцийн 2005 оны нэмэлт, өөрчлөлт; 4. Бага хэмжээний цөмийн материалын 2005 оны шинэчилсэн протокол;	Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн. - Улсын Их Хурлын Аюулгүй Байдал, Гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжиж, УИХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар конвенц, протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэлсэн баталсан. - Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсан тухай шийдвэрийг үндэслэн шинэчилсэн протоколд нэгдсэн тухай захидлыг баталгаажуулан ОУАЭА-т хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг хүссэн 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/746 дугаартай албан бичгийг ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газарт хүргүүлсэн.	
1.3.	Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардал	- Хуулийн төсөл, үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан эсэх; - Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлсэн эсэх; - Хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэсэн эсэх;	- Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах танилцуулга, үзэл баримтлал, үр нөлөөг үнэлэх аргачлал, ЦЭК-ын дүрмийг шинэчлэх тогтоолын төслийг шинэчлэн боловсруулсан. - Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/221 дүгээр тушаалаар Цөмийн энергийн тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	- Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж батлуулна. - Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. - Хуулийн төслийг Засгийн газар, УИХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ.	- Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл, танилцуулга, хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааны тайланг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Цөмийн энергийн комиссын даргад 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 1/18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж, АҮЭБ-ийн сайд, Сангийн сайд, ХЗДХ-ийн сайд нараар батлуулсан. - Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, салбарын хууль эрх зүйн орчинг	100

				үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. - Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлуулсан.		боловсронгуй болгох ажлын хүрээнд ЦЭТХ-ийн төсөл, үндэслэл, танилцуулга мэдээлэл, хуулийн төслийн тандан судалгаа, үр нөлөө, эдийн засгийн үр ашгийн тооцоолол зэрэг мэдээллийг шинэчлэн боловсруулж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Ажлын хэсэгт хүргүүлсэн. Үүнд: - Улс, орнуудын ураны АМНАТ, ААНОТ-ын мэдээлэл (2024 оны байдлаар); - Зарим улс, орнуудын ураны уурхайд нөхөн сэргээлт хийсэн туршлагын талаарх товч мэдээлэл; - Хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаанд ЦИАМ-ын талаарх олон улсын чиг хандлага, үнийн прогнозыг шинэчилсэн; - ГДУО аргаар уран олборлож буй улс орнуудын уурхай, гол эзэмшигч, АМНАТ зэргийг багтаасан мэдээлэл. - Ажлын хэсэг цацраг идэвхт ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэд оруулах, Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2-т заасны дагуу өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох зарчмыг хангуулах, ураныг олборлох, боловсруулах үйл ажиллагаанд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах зохицуулалтыг Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусган боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хуулийн төслийн талаар танилцуулга бэлтгэж, УИХ-ын намын бүлгүүд, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, УИХ-ын чуулганд танилцуулсан. - Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хэлэлцэн баталсан.	
1.4.	Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон нийтлэг дүрэм, журам боловсруулах, батлуулна.	Үйл ажиллагааны зардал	- Боловсруулсан баримт бичгийн тоо;	- 2015-2021 онд Цацрагийн аюулгүйн норм, Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм зэрэг цөмийн болон цацрагийн аюулгүй байдал, цацраг идэвхт ашигт малтмал, цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагаатай холбоотой 23 норм, төлөвлөгөө, дүрэм, журам, стандартыг батлуулсан.	- Цөмийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаатай холбоотой 4 дүрэм, зөвлөмж, гарын авлага боловсруулна.	- ЦЭК-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр дараах 3 дүрэм, журмын төсөл, танилцуулгыг бэлтгэсэн. “Цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт материалыг хадгалалтад авах журам”-ын төсөл; “Байгалийн гаралтай цацраг идэвхт материалтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн мониторинг хийх журам”-ын төсөл; - Цацрагтай ажиллагчдын ажил, мэргэжлийг “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох хөдөлмөрийн хортой нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д тусгуулах тухай; “Байгалийн гаралтай цацраг идэвхт материалтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн мониторинг хийх журам”-ын төслийг ЦЭК-ын	90

				- 2023 онд ЦЭК-ын хуралдаанаар 4 журам, төлөвлөгөө хэлэлцүүлж, батлуулсан.		хуралдаанаар хэлэлцүүлж, ЦЭК-ын 2024 оны 02 дугаар тогтоол гарсан. Журмыг улсын бүртгэлд бүртгүүлэхээр 11 дүгээр сарын 28-ны өдрийн 2/724 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. - ОУАЭА-ийн Эмнэлгийн салбарт ашиглагдаж буй ионжуулагч цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны дүрэм SSG-46-ын 4, 5 дугаар бүлэг “Туяа эмчилгээний аюулгүй ажиллагаа, цацрагийн хамгаалалтын талаарх тусгай зөвлөмжүүд”-ийг орчуулсан. - Дараах техникийн баримт бичгүүдийг орчуулж боловсруулсан: - ПЭТ/КТ-ийн зарчим ба практик” - Цөмийн болон цацрагийн анализ - Аж үйлдвэрийн изотопын хэрэглээ	
Стратегийн зорилт №2. Цөмийн технологи нэвтрүүлэх, аюулгүй ажиллагааг хангуулах;							
2.1.	Цөмийн судалгаа-хөгжүүлэлтийг дэмжих, шаардлагатай суурь бүтцийг бий болгох ажлыг зохион байгуулна.	Улсын төсөв	- Төслийн хэрэгжилт (хувиар); - Санамж бичгийн хэрэгжилтийн хувь /хувиар/;	-2023 онд төслөөр гүйцэтгэх ажлын чиглэл, зорилго, зардлын төсөв тодорхойлж, дараах 3 судалгааны ажил гүйцэтгэсэн. 1. Цөмийн эрчим хүчний дэд бүтцийг хөгжүүлэх судалгаа; 2. Цацраг идэвхт ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахад анхаарах асуудлууд; 3. Цөмийн энергийн салбарыг сурталчлах, гадаад орны туршлага судлах”.	- Цөмийн технологийн судалгаа-хөгжүүлэлтийн ажил явуулах, инновацийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна. - Цөмийн шинжлэх ухаан, технологийн төв (ЦШУТТ) байгуулах санамж бичгийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.	- “Цөмийн эрчим хүчний дэд бүтцийг хөгжүүлэх судалгаа-3” чиглэлд “Цөмийн эрчим хүчний дэд бүтцийг хөгжүүлэх судалгаа”, “Цөмийн энергийн салбарыг сурталчлах, олон улсын туршлага судлах” сэдэвт 2 төсөл хэрэгжүүлсэн. - Төслийн хүрээнд ОУАЭА-тай хамтран 2024 оны 10-р сард “Цөмийн эрчим хүчний дэд бүтцийн асуудал:Үндэсний байр суурь ба эрчим хүчний төлөвлөлт”, 11-р сард “Бага чадлын цөмийн эрчим хүчний станцын ашиглалт ба ерөнхий асуудал”, 12-р сард “Цөмийн эрчим хүчний станцын газар сонголт ба цахилгаан сүлжээ” сэдэвт цуврал үндэсний семинаруудыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Тус семинаруудад ОУАЭА-аас нийт 10 эксперт цөмийн эрчим хүчний хөтөлбөр хэрэгжүүлэх туршлага, цөмийн эрчим хүчний дэд бүтцийн 19 асуудлыг хангах, Засгийн газрын үүрэг, хариуцлага, оролцоо, санхүүжилт, эрчим хүчний төлөвлөлт, стратеги боловсруулах, урьдчилсан ТЭЗҮ бэлтгэх, станцын газар сонголт, эрчим хүчний шугам сүлжээний бэлтгэл зэрэг агуулгын хүрээнд илтгэл хэлэлцүүлсэн. Тус цуврал семинар бүрт эрчим хүч, цөмийн энерги, зам тээвэр, байгаль орчин зэрэг салбаруудын холбогдох яам, агентлаг, их дээд сургуулиуд болон судалгаа шинжилгээний нийт 25-32 байгууллагын 40-70 албан хаагчдыг хамруулж, цөмийн эрчим хүчний хөтөлбөрийг эхлүүлсэн ижил төстэй зарим улсын туршлага, экспертүүдийн зөвлөмж, мэдээллийг холбогдох байгууллага, шийдвэр гаргагчдад хүргэсэн. - “Цөмийн энергийн салбарыг сурталчлах, олон улсын туршлага судлах” төслийн хүрээнд	100

						ОУАЭА-ийн Ерөнхий бага хурлын 68 дугаар чуулганд оролцож, Монгол Улсын цөмийн энергийн салбарын талаар сурталчилж, холбогдох мэдээ, мэдээлл авсан. - “Цөмийн эрчим хүчний дэд бүтцийг хөгжүүлэх судалгаа-3” төслийн нэгдсэн тайланг боловсруулсан. - ЦШУТТ байгуулахад хамтран ажиллах тухай МУИС, “Русатом Оверсиз” ХХК хооронд “Төсөл боловсруулах хэлэлцээр”-ийн хүрээнд Талууд технологийн нууц мэдээлэл солилцох, ашиглах, боловсруулах асуудлыг зохицуулах зорилготой “Нууцлалын гэрээ”-ний нөхцлүүдийг хэлэлцэхэд манай талын бодлого, чиглэлд уялдуулан ажиллах мэдлэг арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлсэн. - “Русатом Оверсиз” ХХК-тай байгуулах “Нууцлалын гэрээ”-ийн төслийг талууд хэлэлцээд, монголын талын саналыг тусган 2024 оны 5 сард оросын талд хүргүүлсэн.	
2.2.	Цөмийн технологийн хэрэглээг нийгэм-эдийн засгийн салбарт өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Үйл ажиллагааны зардал	- Төслийн хэрэгжилт /санхүүжилтийн хувиар/; - Төслийн үр дүн /хувиар/	- ОУАЭА-ийн “Техникийн хамтын ажиллагааны хамрах хүрээ 2022-2027” баримт бичигт тусгагдсан чиглэлийн хүрээнд эрүүл мэнд, хүнс хөдөө аж ахуй, шинжлэх ухаан, цацрагийн хамгаалтын салбарт MON0013, MON6022, MON9010, MON5026 гэсэн 4 үндэсний төсөл хэрэгжсэн. Түүнчлэн өмнөх гэрээний MON5025; MON6020; MON6021; MON1009; MON0012, MON5023, MON5024, MON1008 зэрэг 8 үндэсний төсөл хэрэгжсэн. - ТХА-ны бүс, бүс хоорондын нийт 45 төсөлд Монгол Улсаас 12 байгууллага оролцсон. - Төслүүдийн хүрээнд зохион байгуулагдсан 29 арга хэмжээ (Хурал, уулзалт-7, сургалт-19, семинар-8, танилцах айлчлал-1, дадлагажих сургалт-2)-нд дотоодын	- ОУАЭА-ийн төслүүдийн хүрээнд шинэ технологи дамжуулах, нутагшуулах ажлыг зохион байгуулна. - АНДБХАХ-ийн төслүүдийн хүрээнд шинэ технологи дамжуулах, нутагшуулах ажлыг зохион байгуулна. - АЦХАФ-ын төслүүдийн хүрээнд шинэ технологи дамжуулах, нутагшуулах ажлыг зохион байгуулна.	ОУАЭА-ийн төслийн хүрээнд: Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж: - Нийт 6 төслийн хүрээнд 855,7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан. Үүнд: • MON0012 төслөөр 91.7 сая төгрөгийн шингэн азотын машин, • MON1009 төслөөр 44 сая төгрөгийн тун тохируулагч, радиохимийн лабораторид 294 сая төгрөгийн туслах хэрэглэгдэхүүн, 18 сая төгрөгийн ариутгагч ЦФСТ-д, • MON5026 төслийн хүрээнд 79.1 сая төгрөгийн урсгал эсийн бичил хавтан, түргэвчилсэн аргаар генийн дараалал тогтоох цомог, дагалдах хэрэгсэл, 311 сая төгрөгийн өндөр өсгөлтийн электрон микроскоп МЭХ-д, • MON5025 төслийн хүрээнд 113.9 сая төгрөгийн давхар масс спектрометр, ультра өндөр мэдрэмжит шингэний хроматографийн дагалдах хэрэгсэл, лабораторийн хэрэглэгдэхүүн УМЭАЦТЛ-т, геномын судалгаанд оруулсан ямааг тэмдэглэх 2000 ээмэг, ээмэглэгч, спектрофотометрийн хамт МААЭШХ-д. - 2025 онд 3 төслийн хүрээнд дараах тоног төхөөрөмжийг хүлээн авна. Үүнд: • MON6023 төслөөр УХТЭ-д HPLC, синтисайзер, СПЕКТ/СТ, УНТЭ-д СПЕКТ/СТ тоног төхөөрөмж,	100

				11 байгууллагын 37 албан хаагч хамрагдсан.	• MON0014 төслөөр ЗӨСҮТ-д вирусын инфогенетик шуурхай тодорхойлох NGS иж бүрдэл, • MON7006 төслөөр ШУА-ын ГГХ-д ион хромотограф. Хүний нөөцийн чиглэлээр: - MON0013 төслөөр ХСҮТ-ийн 1 физикч Австрали улсын Канберагийн эмнэлэгт электрон цацрагийн технологийн хүний нөөцийн хөгжүүлэлт чиглэлд 1 сар, УНТЭ-ийн 1 физикч Өмнөд Африкийн Цөмийн энергийн корпорацид Мо-99 генераторын үйлдвэрлэл менежмент чиглэлээр 2 сар, MON6023 төслөөр ХСҮТ-ийн 1 эмч БНЭУ-д хүн дотуур туяа эмчилгээний чиглэлээр 2 сар, Япон улсад 1 физикч стереотактик эмчилгээний төлөвлөлтийн чиглэлээр 6 сар, MON7006 төслөөр ГГХ-ийн 2 судлаач изотоп гидрологийн чиглэлээр БНЭУ-д 5 хоног, MON2010 төслөөр ЦЭК-ын Ажлын албаны 2 албан хаагч БНХАУ-ын цөмийн эрчим хүчний төлөвлөлтийн чиглэлээр 12 хоног, MON5026 төслөөр МЭХ-ийн 1 судлаач Этиоп улсад хил дамнан халдварладаг малын өвчний вирус өсгөвөрийн чиглэлээр 28 хоногийн хугацаатай дадлагажих сургалтад тус тус хамрагдсан. Төслийн хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсад зохион байгуулсан үйл ажиллагаа: - MON6023 төслийн төлөвлөгөөг үндэсний хэмжээнд цогц менежментээр шийдвэрлэхэд зориулж ЭМЯ-ны хүсэлтээр ОУАЭА-аас “Хавдрын эсрэг менежментийн цогц үнэлгээ”-ний багийг Монгол Улсад ажиллуулахаар урьж, 05-р сарын 06-10-ны хооронд 15 шинжээчийн бүрэлдэхүүнтэй 1, 2, 3 дугаар шатлалын эмнэлгүүдийн хавдрын тусламж, үйлчилгээ, хүүхдийн хавдрын эмчилгээний чиглэлд одоо байгаа нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээний зөвлөмж ирүүлсэн. - MON2010 төслөөр Цөмийн эрчим хүчний дэд бүтцийн асуудалтай холбоотой 10, 11, 12-р сард цуврал семинаруудыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан. MON1010 төслийн төлөвлөгөөг нарийвчлан гаргахаар ОУАЭА-ийн техникийн мэргэжилтэн Ханнах Аффум 2 дугаар сард 5 хоног Монгол Улсад ажиллаж, ҮЭС ашиглаж буй одоогийн нөхцөл байдалтай танилцаж, цаашид МГТБҮ ТӨХХК-д ҮЭС-ын лаборатори байгуулах технологийн зөвлөмжийг өгсөн. ОУАЭА-ийн Монгол Улсыг хариуцсан ТХА-ны хэлтсийн төслийн мэргэжилтэн Денис Субботницкий 10 дугаар сард ирж, үндэсний
--	--	--	--	--	--

					төсөл хэрэгжүүлэгч ЭМЯ, ЦЭКАА-ны ЦАББГ, УНТЭ, УХТЭ, ХСҮТ, ЦФСТ, УХЭШХ, ЗӨСҮТ, ГГХ, МЭХ, МГТБҮ ТӨХХК, НҮБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газар, Хүүхдийн сан байгууллагуудын төслийн явцтай танилцаж, зөвлөмж өгсөн. - Үндэсний 11 төслийн 2023 оны PPAR тайланг ОУАЭА-т хүргүүлж, төслүүдийн тайлан хэлэлцүүлэх уулзалтыг чиглэл тус бүрээр зохион байгуулсан. - ТХА-ны 2026-2027 онд хэрэгжих үндэсний төслүүдийн төлөвлөгөөг боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, нэгтгэн ОУАЭА-т хүргүүлсэн. - Төслүүдийн уялдаа, үр өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд төслийн менежментийн гарын авлага бэлтгэх ажилд ОУАЭА-ийн “Designing IAEA Technical Cooperation Projects using the Logical Framework Approach”-ыг эхний бүлгийг орчуулсан. - Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй төр, хувийн хэвшлийн 74 байгууллагаас атом болон цөмийн технологид суурилсан тоног төхөөрөмжийн мэдээллийг цуглуулан анализ хийсэн. Эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй, судалгаа-шинжилгээ, геологи, уул уурхай гэсэн 4 чиглэлээр төрийн 32, хувийн хэвшлийн 16 байгууллагаас ирүүлсэн 805 атом, цөмийн технологид суурилсан тоног, төхөөрөмжийн мэдээлэлд үндэслэн ашиглалт, насжилт, техникийн бүрэн бүтэн байдлын талаар танилцуулга боловсруулсан. АЦХАФ-ын төслийн хүрээнд: - АЦХАФ-ын хүрээнд 8 төсөл эрүүл мэнд, байгаль орчин, хүнс хөдөө аж ахуй, шинжлэх ухаан, цөмийн болон цацрагийн хамгаалалтын чиглэлээр тайлант хугацаанд хэрэгжиж, 6 төслийн зохицуулагчдын уулзалтад МУИС, УГТХ, ГГЭХ, ХАБҮЛЛ, ЦЭК-ын Ажлын алба, УГТХ зэрэг 6 байгууллагын 6 албан хаагчийг биеэр, АЦХАФ-ын Үндэсний зохицуулагчдын 25 дугаар хурал, Техникийн зөвлөгөөнд цахимаар 5 албан хаагчийг оролцуулсан. 2024 онд форумын 25 жилийн ойн тохиож, Токио хотноо болсон баярын хуралд Монгол Улс эдгээр төслүүдэд элсэн орсноос хойш гаргасан амжилт, үр бүтээлийг гишүүн улсуудад танилцуулсан. Эрүүл мэндийн чиглэлээр: - АЦХАФ-ын техникийн зөвлөгөө 2024 “Цацраг идэвхт изотоп болон цөмийн туяаг эмчилгээнд ашиглах нь” сэдвээр зохион байгуулагдаж,
--	--	--	--	--	---

					гишүүн улсуудын цөмийн анагаах ухааны одоогийн түвшин, цаашдын төлөвлөгөөний талаар санал солилцсон. Зөвлөгөөнөөр БНСУ, Австрали улсын чадавх өндөр байгаа нь бүс нутгийн хэрэгцээг хангахад тус дэм болж байгааг цохон тэмдэглээд цаашид Индонез, Малайз зэрэг улсууд дотоодын хэрэгцээг хангах төлөвлөгөөг боловсруулахад Япон зэрэг цөмийн анагаах ухааны чиглэлийн судалгаа, туршилт, эрдэм шинжилгээний олон жилийн туршлагатай, өндөр хөгжилтэй орнууд хамтран ажиллахаар тохиролцов. Цөмийн анагаах ухааны цацраг идэвхт изотопын үйлдвэрлэлийн судалгаанд гишүүн орнуудыг идэвхтэй оролцох нь цаашид дотоодын хэрэгцээг хангах чадавхийг бий болгох, хүний нөөцийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг цохон тэмдэглэсэн. Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: - АЦХАФ-тэй хамтран хэрэгжүүлдэг “Ургамлын мутацын селекцийн бүсийн төслийн зохицуулагчдын ээлжит хурлыг 2024 оны 07 сард Дарханы УГТХ-д зохион байгуулсан. УГТХ-аас тус төслийн хүрээнд өмнө мутацын үржүүлгээр ургац хураах хугацааг богиносгох ажил хийгдэж байсныг 2025 оноос шим тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх болгон өргөтгөж ажиллах төлөвлөгөөг зохицуулагчдын хурлаар танилцуулсан; Манай улс ХАА, хүрээлэн буй орчин, анагаах ухааны салбарт “Цацраг болон полимер өөрчлөлтийг ашиглах нь” төслийн хүрээнд био бордоо, органик бордоог хослуулан хэрэглэж, улаан буудайн ургацыг 9.7%-иар нэмэгдүүлсэн. Мөн хорхой ааруулыг 5 кГр рентген цацрагаар шарахад 4.1*10⁶ -2*10⁵ колони үүсгэгч нэгж болж мэдэгдэхүйц буурсан. Ионжуулагч цацраг туршилтын дээжийн тэжээллэг чанар, амт, гадаад байдал, бүтэц зэрэгт мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлээгүй. 2024 онд шинээр элссэн Хуурамч хүнсний мөшгилтийн төслийн зохицуулагчдын хуралд ХАБҮЛЛ-оос 1 албан хаагч оролцож, Монгол Улсын хувьд хүнсний бүтээгдэхүүний орцод тэмдэглэсэн бүтээгдэхүүн зөрснөөр харшил үүсгэх явдал ихсэж, хүн амын эрүүл мэндийн ноцтой зөрчил үүсгэх болсон тул орц найрлагыг үнэн зөв тогтоох судалгаанд гишүүн улсуудтай хамтран ажиллах саналаа танилцуулсан. АНДБХАХ-ийн төслийн хүрээнд: - АНДБХАХ-ийн Үндэсний зохицуулагчдын 46 дугаар хуралд оролцож, төслийн явц, цаг үеийн мэдээлэлтэй танилцсан. АНДБХАХ-ийн
--	--	--	--	--	---

					боловсрол, шинжлэх ухааны 1, эрүүл мэндийн 10, хүнс, хөдөө аж ахуйн 2, байгаль орчны 3, аж үйлдвэрийн 2, цацрагийн хамгаалалтын 1, нийт 19 бүсийн төсөлд 11 байгууллага оролцож байна. Эдгээр төслийн хэрэгжилтийн хүрээнд: Тоног төхөөрөмж: - ШУА-ийн ГТЭХ-д RAS5091 төслөөр хээрийн болон лабораторийн судалгааны хөрсний ялзмаг, органик нүүрстөрөгчийг тодорхойлох 151.7 сая төгрөгийн өртөгтэй зөөврийн спектрометр, RAS7040 төслөөр усны бүрэн шинжилгээний 31.5 сая төгрөгийн багаж, түүний дагалдах хэрэгслүүд, RAS6101 төслөөр 75 сая төгрөгийн хурдасгуурын чанарын хяналтын багаж, 10 сая төгрөгийн цацрагийн хэмжилтийн 3 төрлийн фантом, 2 төрлийн бэхэлгээ, RAS1028 төслөөр орчны цацрагийн бохирдол хэмжих 60 сая төгрөгийн дозиметрийн багажийг ЦФСТ-д тус тус хүлээн авсан. Хүний нөөцийн чиглэлээр: - 2024 онд эрүүл мэндийн 6 төслийн зохицуулагчдын уулзалт болж, хөнгөвчлөх туяа эмчилгээний эмнэлзүйн гарын авлагын сургагч багш бэлтгэх, хөнгөвчлөх туяа эмчилгээний эмнэлзүйн гарын авлага боловсруулах, эмнэлгийн физикчийн мэргэжлийн хөтөлбөр, тераностик тусламж үйлчилгээ ба яаралтай тусламж, ПЕТ/СТ ба СПЕКТ/СТ-ийн хосолмол дүрс оношилгооны анагаах ухааны хэрэглээний суурь, Фтор 18 ба бусад тэмдэгт атомын дүрс оношилгоо, туяа эмчилгээ ба дүрс оношилгоонд эмнэлгийн физикчийн үүрэг хариуцлага, туяа эмчилгээний цар хүрээг өргөтгөх нь зэрэг 8 бүсийн сургалтад мэргэжлийн 5 байгууллагын 15 албан хаагчийг мэргэшүүлсэн. - АНДБХАХ-ийн бусад үйл ажиллагаа: Ковид 19 цар тахлын үед Монгол Улсад хандивлахаар төлөвлөсөн 113 сая төгрөгийн аппаратыг Хөвсгөл аймгийн ЭМГ-т нийлүүлж, ОУАЭА-ын хандиваар өмнөх онуудад нийлүүлсэн 7 рентген, 5 эхо аппаратууд хэвийн ажиллаж, рентген, эхо оношилгоо хийдэггүй байсан алслагдмал сумдуудын Эрүүл мэндийн төвд иргэдэд үйлчилж байна. - Засгийн газрын “Хүнс хөдөө аж ахуй, аж үйлдвэр, хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах салбарт электрон цацрагийн технологи, түүний хэрэглээг дэмжих нь” төслийн хүрээнд ХХААХҮЯ, ХАБҮЛЛ-аас 2 албан хаагчийг АНУ-ын Техасын Их сургуульд зохион байгуулагдсан эмнэлгийн хэрэгсэл, эм зүй, биотехнологийн салбарт
--	--	--	--	--	---

						ариутгал халдваргүйжүүлэлтийг электрон цацраг болон рентген технологи ашиглах, шинэ хүнс, шинэхэн бүтээгдэхүүн, ургамлын эрүүл ахуй, тэжээвэр амьтдын хоол, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд электрон цацраг болон рентген технологийн тухай “Электрон цацрагийн технологийн дадлага сургалт”-д хамруулсан.	
2.3.	Цөмийн энергийн салбарын хүний нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардал	- “Цөмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн төслийг хэлэлцүүлсэн эсэх; - Бэлтгэгдсэн хүний нөөцийн тоо; - Мэдээллийн сангийн хэрэгжилтийн хувь /хувиар/;	- “Цөмийн энергийн салбарын хүний нөөцийн хөгжлийн стратеги”-ийн төслийг боловсруулсан. - ЦЭК-ын Ажлын албаны даргын 2020 оны А/27 дугаар тушаалаар Мэдлэгийн менежмент нэвтрүүлэх багийг байгуулж, ажлын төлөвлөгөө батлан ажилласан.	- “Цөмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр ба төлөвлөгөө”-г цөмийн эрчим хүчийг ашиглах судалгааны ажлын хүрээнд боловсруулна. - Цөмийн мэдлэгийн менежментийг нэвтрүүлж, цөмийн энергийн салбарын мэдээллийн санг бий болгоно.	- Цөмийн энергийн салбарын хүний нөөцийн хөгжлийн асуудлаар өмнө бэлтгэсэн тайлан, танилцуулгыг судалж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулсан. Энэ хүрээнд цөмийн технологи ашигладаг судалгаа шинжилгээний болон холбогдох 56 байгууллагуудаас цөмийн чиглэлийн хүний нөөц, өнөөгийн байдал, хэрэгцээ шаардлагын талаарх мэдээллийг цуглуулсан. - “Монголын цацрагийн хамгаалалтын нийгэмлэг” ТББ-тай хамтран цацрагийн хамгаалалтын 19 удаагийн сургалтыг зохион байгуулж, 175 байгууллагын 578 цацрагтай ажиллагчийг хамруулсан. - Цөмийн болон цацрагийн ослын бэлэн байдал” сэдэвт дагалдах сургалтын 10 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд зохион байгуулж, цацрагийн ослын бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх холбогдох 14 байгууллагын 21 албан хаагчийг хамруулсан. - Гадаад орчны цацрагийн хяналт” сэдэвт дагалдах сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 27-31-ний өдрүүдэд зохион байгуулж, цацрагийн хяналт, хэмжилт шинжилгээ хийх чиг үүрэг бүхий төрийн захиргааны болон судалгаа шинжилгээний 15 байгууллагын 22 албан хаагчийг хамруулсан. - Олон Улсын цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны оролцоо хөтөлбөрийн хүрээнд ЦЭК-ын Ажлын алба, АНУ-ын Эрчим хүчний яам, Үндэсний цөмийн аюулгүй байдлын газартай хамтран “Үндэсний хяналт шалгалт” сэдэвт сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд зохион байгуулж, холбогдох төрийн 11 байгууллагын 23 албан хаагчийг хамруулсан. - АНУ-ын Эрчим хүчний яам, Цацрагийн аюулгүй байдлын газар, Сандиагийн үндэсний лабораторитой хамтран “Цацрагийн үүсгүүр бүхий байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах” сэдэвт сургалтыг 2024 оны 07 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулж, цацраг идэвхт үүсгүүр хэрэглэгч 7 байгууллага, аюулгүй байдлыг хангах, хариу арга хэмжээ үзүүлэх чиг үүрэг	50

						бүхий 10 байгууллагын нийт 32 албан хаагчийг хамруулсан. - ОУАЭА-ийн Хяналтын байгууллагын мэдээллийн систем (RAIS+ - Regulatory Authority Information System)-ийг серверт суулган, орчуулга, тохируулгыг хийж, дотоод сүлжээнд холбож, Цөмийн энергийн салбарын бүртгэл, мэдээллийн систем болгон ашиглахад бэлэн болгосон. - Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгаа, олон улсын гэрээ, конвенцтой холбоотой мэдээлэл, цөмийн болон цацрагийн ослын бэлэн байдал, Монгол Улсын хэмжээнд ашиглаж, хадгалж буй цацрагийн үүсгүүрийн бүртгэл судалгааны танилцуулга, “Цөмийн болон цацраг идэвхт материалын аюулгүй байдал, ОУАЭА-ийн зөрчил, хууль бус хөдөлгөөний мэдээллийн сангийн талаар танилцуулга мэдээлэл боловсруулсан. - Чухал далд мэдлэгийг хадгалах зорилгоор МУИС-ийн Цөмийн физикийн судалгааны төвийн эрдэм, шинжилгээний ахлах ажилтантай “Цөмийн эрчим хүчний тухай” видео ярилцлага хийсэн. - ОУАЭА-ийн ТХА-ны 2026-2027 оны циклд дэвшүүлж буй төсөлд Мэдлэгийн менежменттэй холбогдох хэсэг Мэдлэгийн менежментийн замын зураглал боловсруулахаар мэдээллийг оруулсан. - Байгууллагын хэмжээнд мэдлэг, мэдээлэл солилцох мэдлэгийн кафег ажиллуулан, мэдээлэл бэлтгэн албан хаагчдад танилцуулж хэлэлцүүлж, 30 гаруй удаа дотоод сургалт зохион байгуулсан.	
2.4.	Цөмийн бодис, цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангуулах, зөвшөөрөл олгох, санал өгөх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардал	- Хуулийн хэрэгжилт /хувиар/; - Өгсөн саналын тоо; - Цахим системийг хөтөлсөн эсэх;	- Цөмийн энергийн тухай хуулийн 15.1.3-т заасан үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл хүсч, ирүүлсэн материалд үнэлгээ хийж, 1 байгууллагад цөмийн бодис эзэмших, ашиглах зөвшөөрөл олгосон. - 2023 онд БШУЯ-наас portal.igov.mn цахим системээр ирүүлсэн цацрагийн үүсгүүр ашиглах, хадгалах эрхийн тусгай зөвшөөрөл хүссэн 52, цацрагийн үүсгүүр импортлох эрхийн тусгай зөвшөөрөл	- Цөмийн энергийн тухай хуулийн 15.1-д заасан тусгай зөвшөөрөл олгоно. - Цөмийн энергийн тухай хуулийн 15.2, 15.3-т заасан тусгай зөвшөөрөл олгоход санал өгнө.	- Тайлант хугацаанд Цөмийн энергийн тухай хуулийн 15.1-д заасан тусгай зөвшөөрөл хүссэн материал ирээгүй. - АҮЭБЯ-наас portal.igov.mn цахим системээр ирүүлсэн цацрагийн үүсгүүр ашиглах, хадгалах эрхийн тусгай зөвшөөрөл хүссэн 131, цацрагийн үүсгүүр импортлох эрхийн тусгай зөвшөөрөл хүссэн 130, цацрагийн үүсгүүр тээвэрлэх тусгай зөвшөөрөл хүссэн (давхардсан тоогоор) 21, цацрагийн үүсгүүр экспортлох эрхийн тусгай зөвшөөрөл хүссэн 15 аж ахуйн нэгж, байгууллагын материал болон Улсын байцаагчийн үнэлгээний дүнтэй тухай бүр танилцаж, үнэлгээ хийн зөвшөөрөл олгох эсэхэд санал хүргүүлсэн.	100

				хүссэн 88, цацрагийн үүсгүүр тээвэрлэх тусгай зөвшөөрөл давхардсан тоогоор 9, цацрагийн үүсгүүр экспортлох эрхийн тусгай зөвшөөрөл хүссэн 3, цацраг идэвхт изотоп худалдах эрхийн тусгай зөвшөөрөл хүссэн 1 аж ахуйн нэгж, байгууллагын материал болон Улсын байцаагчийн үнэлгээний дүнтэй тухай бүр танилцаж, үнэлгээ хийн зөвшөөрөл олгох эсэхэд саналыг хүргүүлсэн.			
Стратегийн зорилт №3. Цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг хангах;							
3.1.	Цөмийн эрчим хүчний эх үүсвэрийн дэд бүтцийн судалгаа хийнэ.	Үйл ажиллагааны зардал	- Судалгааг хүлээн зөвшөөрөгдөхүйц арга аргачлалаар хийсэн эсэх; - Хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэх;	- “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалт 2.10, Засгийн газрын 2022 оны 16 дугаар хуралдааны тэмдэглэлийг үндэслэн БШУ-ны сайд, ЭХ-ны сайд, УУХҮ-ийн сайд нарын хамтарсан тушаалаар батлагдсан ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, “Монгол Улсад ЦЭХ-ний эх үүсвэр ашиглах үндэслэл боловсруулах”, “ЦЭХ-ний эдийн засгийн товч мэдээлэл боловсруулах” ажлын даалгаврын тайланг боловсруулсан.	- Монгол орны хэмжээнд тохиромжтой цөмийн эрчим хүчний эх үүсвэрийн сонголт, өрсөлдөх чадварын харьцуулсан судалгаа хийх ажлыг зохион байгуулна. - Цөмийн эрчим хүчний станцын аюулгүй ажиллагаатай холбоотой шаардлагуудыг ОУАЭА-аас гаргасан баримт бичигт үндэслэн үндэсний хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулна.	- 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн Засгийн газрын 13 дугаар хуралдаанд “Цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг Монгол Улсад ашиглах суурь судалгааг эхлүүлж, цаашид баримтлах бодлогын чиглэлийн санал боловсруулах ажлын хэсгийн тайлангийн талаар БШУЯ-ны сайд, ЦЭХ-ын дарга Л.Энх-Амгалан танилцуулсан. Хуралдаанаас ОУАЭА-ийн “Цөмийн эрчим хүчний дэд бүтцийг хөгжүүлэх зөвлөмж”-ийн дагуу цөмийн эрчим хүчний станцын дэд бүтцийн үндсэн 19 асуудлыг судалж, урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулан танилцуулахыг БШУЯ-ны сайд, ЦЭХ-ын дарга Л.Энх-Амгалан даалгасан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсад цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах суурь судалгааг эхлүүлж, цаашид баримтлах бодлогын чиглэлийн санал боловсруулах ажлын хэсгийн тайлан болон цөмийн эрчим хүчний чиглэлээр ШУА дээр зохион байгуулагдсан “Монголын эрчим хүчний систем ба цөмийн эрчим хүчийг ашиглах боломж” эрдэм шинжилгээний хурал-хэлэлцүүлгээс УИХ, Засгийн газарт хандаж гаргасан зөвлөмж, БШУ-ны сайдын тушаалын төсөл болон шаардагдах зардлыг 2025 оны төсөвт оруулахад дэмжлэг хүссэн албан бичгийн хамт БШУЯ-нд хүргүүлсэн. - IV үеийн бага чадлын цөмийн эрчим хүчний реакторын мэдээлэл, аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, технологи, төсөл хэрэгжиж буй түвшин, тэгшитгэсэн үнийн тооцооллын талаар мэдээлэл боловсруулж, Бага чадлын модуляр реакторын харьцуулсан судалгаа хийсэн	80

					- Улс орнуудын хэмжээнд хөгжүүлэлтийн үе шатанд явагдаж буй GE Hitachi-BWRX300, NuScale-VOYGR, RosAtom-RITM200, CNNC-ACP100, EDF-NuWard, KAERI-SMART, Rolls Royce бага чадлын модуляр реакторын эдийн засаг, технологи, загвар дизайны үзүүлэлтийн талаар мэдээлэл бэлтгэсэн. - ЭХЯ, ЦЭК, ШУА-аас “Монголын эрчим хүчний систем ба цөмийн эрчим хүчнийг ашиглах боломж” эрдэм шинжилгээний хурал-хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулж, “Монгол Улсад цөмийн эрчим хүчийг ашиглах төрийн бодлогыг хэрэгжүүлэх арга зам” сэдэвт илтгэл хэлэлцүүлэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээж, УИХ, ЗГ, холбогдох яам, байгууллагуудад Цөмийн эрчим хүчний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгж (NEPIO)-ийг байгуулах, Цөмийн эрчим хүчний хөгжүүлэлтийн талаарх олон улсын хандлагыг анхааралдаа авч, Монгол Улсын урт хугацааны бодлого, “Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”, Цөмийн энергийн тухай хууль, тэдгээрийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг уялдуулан үйл ажиллагааг нь зохицуулах төрийн захиргааны байгууллага - Цөмийн энергийн газрыг сэргээн байгуулах, цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн эрчим хүчийг ашиглах нь эдийн засгийн төдийгүй стратегийн ач холбогдолтойг анхааралдаа авч үндэсний зөвшилцөлд хүрч, төрөөс баримтлах бодлогыг тогтвортой, тууштай байлгах тал дээр арга хэмжээ авч ажиллахыг уриалсан зөвлөмжийг гаргасан. - ОУАЭА-ийн ТХА-ны MON2010 “Цөмийн эрчим хүчийг ашиглах боломжийг үнэлэх болон цөмийн цацрагийн аюулгүй байдлыг бэхжүүлэх” төслийн төлөвлөгөөнд туссан гүйцэтгэвэл зохих 5 ажлаас 4 ажил (цахилгаан сүлжээ, газрын сонголт, үндэсний байр суурь, эрчим хүчний төлөвлөлтийн зөвлөх үйлчилгээ)-ыг гүйцэтгэж, эрчим хүчний төлөвлөлтийн сургалтын ажлыг 2025 оны эхний хагаст хэрэгжүүлэхээр хойшлуулсан. - Монгол Улс ОУАЭА-ийн “Олон улсын цөмийн реакторын инноваци ба түлшний цикл” (ИНПРО) төсөлд нэгдэх ажлыг зохион байгуулж, төслийн 46 дахь гишүүнээр албан ёсоор элссэн. Ирэх онуудаас тус төслийн үйл ажиллагаануудад идэвхтэй оролцож, цөмийн эрчим хүчний төсөлд ашиглахаар төлөвлөж байна.
--	--	--	--	--	---

						- ОУАЭА-аас гаргасан дараах баримт бичгүүдийг орчуулсан. Үүнд: • “Цацраг идэвхт хаягдлын ангилал” No.GSG-1”; • “Цацраг идэвхт хаягдлын булшлалт, аюулгүй ажиллагааны шаардлагын стандарт - SSR-5”; • “Цөмийн байгууламж болон үйл ажиллагаанд зориулсан аюулгүй ажиллагааны үнэлгээ буюу GSR Part -4”.	
Стратегийн зорилт №4. Цацраг идэвхт ашигт малтмалын үйл ажиллагааг эрчимжүүлэх;							
4.1.	Цацраг идэвхт ашигт малтмал (ЦИАМ)-ыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлнэ.	Үйл ажиллагааны зардал	- Тогтоолын хэрэгжилтийн хувь; - Хөрөнгө оруулалтын гэрээг боловсруулсан эсэх; - Бэлтгэл ажлыг зохион байгуулсан эсэх;	- Монгол Улсын ЦИАМ-ын ордын батлагдсан нөөцийн нийт хэмжээ 192,241.02 тонн бөгөөд улсын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 4 аймгийн 9 сумын нутагт нийт 104.86 мянган гектар талбайд ЦИАМ-ын хайгуулын 3, ашиглалтын 7 тусгай зөвшөөрлийг 7 ААН эзэмшиж байна. - ЦЭК-ын 2015 оны 05 дугаар тогтоолоор чиглэл болгосны дагуу АМТГТ-аас 167 нэгж талбар бүхий 4.5 сая гектар талбайг бусад төрлийн ашигт малтмалаас ялган Кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн байсан.	- Цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд ЦЭК-ын тогтоолын хэрэгжилтийг хангуулна. - Орано Майнинг компанитай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээг эцэслэн боловсруулна. - Цацраг идэвхт ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой бэлтгэл ажлыг зохион байгуулна.	- Ерөнхий сайдын 2023 оны 91 дүгээр захирамжаар хөрөнгө оруулалтын гэрээний төслийг эцэслэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Ерөнхий сайдын 2023 оны 164, 2024 оны 27 дугаар захирамжаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 удаа шинэчлэн байгуулсан. Тус захирамжийн дагуу ЗГХЭГ-ын даргын 2023 оны 97 дугаар тушаалаар Ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Гэрээ, эрх зүй асуудал хариуцсан, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан, Татвар, санхүүгийн асуудал хариуцсан, Олборлолт, үйлдвэрлэл, технологийн асуудал хариуцсан, Байгаль орчин, орон нутгийн асуудал хариуцсан, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан нийт 6 дэд ажлын хэсгүүдийг байгуулсан. Эдгээр дэд ажлын хэсгүүдийг ЗГХЭГ-ын даргын 2024 оны 93 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, төсөлд оруулах саналыг хамтран хэлэлцсэн. - Гэрээний төсөлтэй холбогдуулан Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9-д заасан төрийн санд байршуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг тус хуулийн 28.10-т заасны дагуу тогтоохоор БОАЖЯ, БШУЯ, УУХҮЯ, Сангийн яам, ЦЭК-ын Ажлын алба, хөндлөнгийн шинжээчийн төлөөллүүд хуралдсан Тус ажлын хүрээнд Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт байрлах “Бадрах энерги” ХХК-ийн ураны уурхайд ураны олборлолт, боловсруулалт, тээвэрлэлтийн үеийн үйл ажиллагаанд “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх тухай” 01/44 дугаартай албан бичгийг Онцгой байдлын ерөнхий газарт, “Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх тухай” 01/36 дугаартай албан бичгийг Эрүүл мэндийн яаманд тус тус хүргүүлсэн. - Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 1/363 дугаартай албан бичгээр Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх тухай, Эрүүл мэндийн сайдын 2024 оны	100

						03 дугаар сарын 06-ны өдрийн 1а/968 дугаартай албан бичгээр Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх тухай албан бичгийг “Бадрах энерги” ХХК-д тус тус хүргүүлсэн. - Гэрээ, эрх зүйн асуудал хариуцсан ажлын дэд хэсэг Англи улсын “White and Case” хуулийн фирмээс, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ажлын дэд хэсэг АНУ-ын “CRA-Charles River Associates”-аас, Байгаль орчин, орон нутгийн асуудал хариуцсан дэд ажлын хэсэг Германы “GeoEnergy Consalt”-аас тус тусын чиг үүргийн дагуу нийт 3 зөвлөх үйлчилгээ авсан. - Хөрөнгө оруулалтын гэрээний “Дэд ажлын хэсэг”-ээс 2024 оны 08 дугаар сарын 20-нд ЗГХЭГ-ын дарга болон Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдад, 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр ҮАБЗ-д тус тус Орано майнинг групптэй байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний явц, зарчмын зөрүүтэй саналын талаар дэлгэрэнгүй танилцуулга мэдээлэл хийсэн. - Хөрөнгө оруулалтын гэрээний шинэ төсөлд “Байгаль орчин, орон нутгийн асуудал” хэсэгт цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах, хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах хяналт, мониторинг засвар арчилгааны зардлыг Монгол банкны валютын тусгай дансанд байршуулах, хаалтын төлөвлөгөөг үйл ажиллагаа эхлэхээс өмнө боловсруулж батлуулах, цацраг идэвхт хаягдлын менежментийг бүрэн гүйцэтгэх, үйл ажиллагаа эхлэхээс өмнөх байгаль орчны суурь үзүүлэлтийг гэрээнд хавсаргах зэрэг холбогдох заалтуудыг тусгасан. - Хөрөнгө оруулалтыг гэрээ боловсруулах ажлын хүрээнд 2024 онд нэгдсэн санал боловсруулах вакуум хурлыг 4 удаа зохион байгуулсан. Гэрээ эрх зүйн ажлын дэд хэсгээс 19 заалт, 5 хавсралт бүхий гэрээний төслийг боловсруулсан бөгөөд нэгдсэн ажлын хэсгээс тус ХОГ-ний төслийг боловсруулж, Францын талд хүргүүлсэн. - “Бадрах Энержи” ХХК-иас ТЭЗҮ-ийн тодотголоо 2024 оны 03 сард шинжээчдийн багт илгээж, шинжээчдийн багаас 89 асуулт тавьсан. Хариултыг одоогоор ирүүлээгүй байна. - “Бадрах Энержи” ХХК-ийн ТУЗ хурал 2 удаа хуралдсан ба 2024 оны III улирлын байдлаар тус компани 68 ажиллагсадтай байгаа бол 2025 оны жилийн эцэст 159 болж нэмэгдүүлэхээр (90 ажилтан авна) хүний нөөцөө төлөвлөсөн. Нарийвчилсан хайгуулын өрөмдлөгөөр 2025,
--	--	--	--	--	--	--

						2026 онд нийт 150 цооног, 33,000 тууш метр өрөмдөхөөр төлөвлөсөн байна. Өр төлбөрийн хэмжээ 2024 оны хагас жилийн байдлаар нийт 79 сая ам.доллар болсон байна. - "Гурвансайхан" ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн асуудлаар байгуулагдсан Ажлын хэсгийн санал дүгнэлтийг 2024.06.06-ны өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж, Ажлын хэсгийн санал дүгнэлтийн дагуу шийдвэрлэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. - Татварын ерөнхий газраас "Гурвансайхан" ХХК-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалтгалтаар тогтоосон 190 сая төгрөгийн төлбөрийг суутган тооцуулж, барагдуулсан байна. - "Гурвансайхан" ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг нэмэгдүүлэх тухай ЦЭК-т ирүүлсэн хүсэлтийн дагуу Татварын ерөнхий газраас тодруулга, санал авсан. - Тайлант хугацаанд ЗГХЭГ, "Геологийн судалгаа, шинжилгээний төв" ТӨҮГ, Татварын ерөнхий газар, "Бадрах Энержи" ХХК, "Адамас Майнинг" ХХК, "Гурвансайхан" ХХК, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мал эмнэлгийн хүрээлэн, "Ди Ти Юу" ХХК, ШУА-ийн Газарзүй, геозкологийн хүрээлэн, ROWEN LEGAL хуулийн фирм зэрэг төрийн болон хувийн байгууллагаас ирүүлсэн 14 санал хүсэлтийг шийдвэрлэсэн. Мөн "Эвийн хүч, эх нутгийн төлөө" НҮТББ, "Их бага баян шарга" НҮТББ-ийн хүсэлтийн дагуу уулзалт хийсэн.	
Стратегийн зорилт №5. Цөмийн болон цацрагийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангуулах;							
5.1.	Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардал	- Мэдээллийг хугацаанд нь хүргүүлсэн эсэх; - RASIMS-ийн хэрэгжилт /хувиар/;	- Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОУАЭА хооронд байгуулсан хэлэлцээрийн нэмэлт протоколын дагуу 2022, 2023 оны мэдүүлгүүдийг ОУАЭА-т хүргүүлсэн. - ОУАЭА-ийн байцаагчид Зөөвч-Овоо ордын ГДУО технологийн туршилтын талбайд цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааны нэвтрэх үзлэг хийж, цөмийн материалын бүртгэлийг магадлан шалгаж, тухайн	- Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих арга хэмжээг зохион байгуулж, ОУАЭА-т шаардлагатай мэдээ, тайланг хугацаанд нь хүргүүлнэ. - ОУАЭА-ийн Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны дэд бүтцийн мэдээллийн систем (RASIMS)-д TSA-1-Цацрагийн хяналтын дэд бүтэц, TSA-2-Ажлын байран дахь мэргэжлийн шарлагын цацрагийн хамгаалалт, TSA-3-Эмнэлгийн шарлагын цацрагийн хамгаалалт, TSA-4-Хүн ам гадаад орчны цацрагийн хамгаалалт, TSA-6-Цацрагийн хамгаалалтын сургалт, боловсрол, TSA-7-Тээвэрлэлтийн аюулгүй ажиллагаа зэрэг чиглэлээр авч	- ОУАЭА-аас 2024 оны 02 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулсан гишүүн орнуудын цөмийн болон цацрагийн ослын нөхцөлд мэдээлэл хүлээн авах, дамжуулах сувгийг шалгах ConvEx-1b олон улсын дасгал, сургуулилтад оролцож, ослын мэдээллийг шуурхай хүлээн авсан тухай баталгаажуулах мессежийг ОУАЭА-ийн Цөмийн болон цацрагийн ослын шуурхай мэдээллийн систем (USIE)-ээр хүргүүлсэн. - Терроризмтой тэмцэх зөвлөлөөс 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 дугаар тогтоолын хүрээнд тус тогтоолыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хэсгийн гишүүдэд стратегийн худалдааны хяналтын хууль, эрх зүйн орчныг бий болгох хэрэгцээ, шаардлага, ач холбогдлын талаар мэдээлэл өгөх арга хэмжээнд Монгол Улсын нэгдэн орохоор	100

				бүтээгдэхүүний найрлага, цэвэр байдлын түвшинг тодорхойлох зорилгоор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс дээж авсан. Дээжийг ОУАЭА-ийн Сейберсдорфын лаборатори руу хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. - ОУАЭА-ийн ослын шуурхай мэдээллийн систем (USIE)-ээр дамжуулан ConvEx-1b, 2a дасгал, сургуулилтад тогтмол оролцож байна, мөн олон улсад болсон осол, зөрчлийн мэдээллийг шуурхай авч бэлэн байдлыг ханган ажиллаж байна.	хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээллийг оруулж, дээрх 7 чиглэлээр дэд бүтцийг боловсронгуй болгох арга хэмжээг зохион байгуулна.	төлөвлөж буй олон улсын протокол, конвенцуудын талаар илтгэл тавьж, нэгдэн орох явцын талаар мэдээлэл өгсөн. - “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал болон цөмийн зэвсгээс ангид статусын тухай” НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 77/56 тогтоолын хэрэгжилтийн талаарх үндэсний тайланд ЦЭК-ын 2023-2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг англи хэл дээр бэлтгэж, ГХЯ-нд хүргүүлсэн. - АНУ-ын ЭХЯ, Үндэсний цөмийн аюулгүй байдлын газар, Олон улсын цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны оролцоо хөтөлбөр, ОУАЭА-аас тус тус зохион байгуулсан 3 удаагийн вэбинарт оролцож, Монгол Улсын нэмэлт протоколын хэрэгжилт, ОУАЭА-ийн байцаагчдын нэмэлт нэвтрэх эрх (CA) авах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулсан тухай туршлагаас хуваалцсан. - Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай Монгол Улс, ОУАЭА хооронд байгуулсан хэлэлцээрт оруулсан Нэмэлт протоколын дагуу Монгол Улсын 2023 оны мэдүүлгийг боловсруулж, ОУАЭА-аас шинэчлэн гаргасан Protocol Reporter 3+ программд мэдүүлгүүдийг боловсруулж, цахимаар хүргүүлсэн. - ОУАЭА-ийн Ерөнхий захирлын орлогч бөгөөд Баталгааны газрын захирал Массимо Апаро 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн DDGO-2024-10-202 дугаартай албан захидлыг Цөмийн энергийн комиссын дарга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваанд ирүүлснийг монгол хэлнээ орчуулж, 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 1/625 дугаартай албан бичгээр АҮЭБЯ-нд хүргүүлсэн. - БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газраас ирүүлсэн хүсэлтийг ОУАЭА-т уламжилж Цацрагийн аюулгүй ажиллагааны мэдээллийн менежментийн систем (RASIMS)-ийн TSA 1, TSA 2, TSA 3, TSA 4, TSA 6, TSA 7 чиглэлээр Монгол Улсын оруулсан мэдээллийг харах эрхийг олгосон. - ОУАЭА-ийн Цацрагийн аюулгүй ажиллагааны мэдээллийн менежментийн систем (RASIMS)-ийн TSA-1 Цацрагийн хяналтын дэд бүтэц, TSA-2 Ажлын байран дахь мэргэжлийн шарлагын цацрагийн хамгаалалт, TSA-3 Эмнэлгийн шарлагын цацрагийн хамгаалалт, TSA-4 Хүн ам гадаад орчны цацрагийн хамгаалалт, TSA-6 Цацрагийн хамгаалалтын сургалт, боловсрол,
--	--	--	--	---	--	---

						TSA-7 Тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны чиглэлээр оруулсан мэдээлэл, түүнд ОУАЭА-ийн экспертүүд үнэлгээ хийсэн байдлын талаар БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газарт мэдээлэл өгсөн. - ОУАЭА, Олон улсын хавдар судлалын агентлаг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Монгол Улсад хавдрын хяналтын чиглэлээр цогц үнэлгээ хийх ажлын хүрээнд Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын чиглэлээр үнэлгээ хийсэн. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын чиглэлээр хийсэн үнэлгээний нэгдсэн танилцуулга болон Монгол Улсын цацрагийн аюулгүй ажиллагааны мэдээллийн менежментийн систем (RASIMS)-ийн тухай ОУАЭА-ийн экспертүүдэд тус тус танилцуулж, асуулт, тодруулгад тайлбар, хариулт өгсөн. - ОУАЭА-аас ирүүлсэн "imPACT Asseesment"-ийн тайлан зөвлөмжтэй танилцаж, холбогдох засваруудыг тайланд тусгаж, хүргүүлсэн. - Ослын бэлэн байдал, хариу арга хэмжээний мэдээллийн менежментийн систем (EPRIMS)-ийн 25 шаардлагын мэдээллийг шинэчлэн системд оруулсан.	
5.2.	Цөмийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулна.	Үйл ажиллагааны зардал	- Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт /хувиар/; - Биет хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулсан эсэх /хувиар/;	- "Цөмийн аюулгүй байдлыг хангах замын зураглал", "Цөмийн аюулгүй байдлыг хангах замын зураглалыг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-г ЦЭК-ын хуралдаанаар батлуулсан. - ОУАЭА-ийн "Цацраг идэвхт үүсгүүрийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын зохицуулах дүрэм", "Цацраг идэвхт үүсгүүрийн импорт, экспортын нэмэлт заавар", "Ашиглагдахгүй болсон үүсгүүрийн менежментийн нэмэлт заавар"-ыг дэмжих тухай албан ёсны байр суурийг илэрхийлэх албан бичгийг ОУАЭА-г хүргүүлэх асуудлыг ЦЭК-ын 08 дугаар сарын 02-	- Цөмийн аюулгүй байдлыг хангах хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан ажиллана. - 1 ба 2 дугаар ангиллын үүсгүүр бүхий байгууламжийн биет хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулна.	- ЦЭК-ын 2023 оны 07 дугаар тогтоолоор баталсан "Цөмийн аюулгүй байдлыг хангах замын зураглалыг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий 17 байгууллагад батлагдсан замын зураглал, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хүргүүлж, хэрэгжилтийн тайланг тухай бүр ирүүлэхийг мэдэгдсэн албан бичиг хүргүүлсэн. - ТЕГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр тус газрын албан хаагчдад "Цөмийн болон цацрагийн аюулгүй байдал" сэдвээр мэдээлэл хийсэн. - ЦЭК-ын Ажлын албаны Изотоп контор, ХСҮТ, ШУА-ын ФТХ-ийн цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах биет хамгаалалтын системийн засвар үйлчилгээний ажлыг АНУ-ын ЭХЯ, Сандиагийн үндэсний лабораторийн санхүүжилтээр гэрээлэгч компани болох "Воч Лайн" ХХК-иар гүйцэтгүүлэхээр 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2 жилийн хугацаагаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулсан. - Цацраг идэвхт үүсгүүр бүхий объектуудын дүрс хяналтын системийг шинэчлэн сайжруулах ажлыг зохион байгуулж, ХСҮТ-ийн камерын хяналтын системийг шинэчилсэн.	100

				ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, албан бичгийг Гадаад харилцааны сайдаар ОУАЭА-ийн Ерөнхий захиралд хүргүүлсэн. - АНУ-ын Эрчим хүчний яамны Цацрагийн аюулгүй байдлын газар, Сандиагийн үндэсний лабораторитой хамтран Ажлын албаны Изотоп контор, ХСҮТ, ЦФСТ-ийн биет хамгаалалтын хэвийн ажиллагааг хангуулсан.		- ОУАЭА-ийн Цөмийн материал цацраг идэвхт үүсгүүрийн хууль бус хөдөлгөөний мэдээллийн санд 2024 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар бүртгэгдсэн 142 хууль бус хөдөлгөөний мэдээллийг нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийсэн. Хууль бус хөдөлгөөний мэдээллийг ЦЭК-ын дэргэдэх Цацрагийн аюулгүйн зөвлөлд танилцуулсан. - БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, ГЕГ, ХХЕГ, ЦЭК-ын Ажлын албатай хамтран ажиллах журам (цацрагийн үүсгүүрийн хууль бус хөдөлгөөнд хяналт тавих)-ийн төслийг боловсруулж, холбогдох байгууллагын саналуудыг тусгасан.	
5.3.	Хүн амын шарлагын цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулна.	Үйл ажиллагааны зардал	- Ослоос сэргийлэх, бэлэн байдлыг хангасан эсэх /хувиар/ - Ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт /хувиар/; - Цацрагийн мониторингийн дүнг нэгтгэсэн эсэх;	- ОУАЭА-аас идэвхгүй радон детекторын систем, 2000 ширхэг детекторын хамт хүлээн авч Радоны лабораторийг байгуулсан. Хүлээн авсан идэвхгүй радон детекторыг монгол орны хэмжээнд байх цаг уурын хэмжилтийн станцуудыг сургууль цэцэрлэгт тараан байршуулсан. Нийслэл хотод байршуулсан детекторууд болон цаг уурын станцад 3 сарын турш байршуулсан CR-39 детекторуудад хэмжилт хийж, радоны агууламжийг тодорхойлсон. - ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригад, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангитай хамтран “Цацрагийн ослын хариу арга хэмжээ” сэдэвт хамтарсан арга хэмжээг 2 удаа зохион байгуулсан.	- Хүн ам, байгаль орчныг цацрагийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх, цөмийн болон цацрагийн болзошгүй ослоос сэргийлэх, бэлэн байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ. - Цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагаанд аюулгүй ажиллагааг хангуулах, хүн ам, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. - Орчны цацрагийн мониторинг болон байгалийн гаралтай цацраг идэвхт материалтай холбоотой цацрагийн мониторингийн дүнг нэгтгэн боловсруулна.	- Цацрагийн ослоос хамгаалах үйл ажиллагааны улсын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: - Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан “Цацрагийн ослоос хамгаалах үйл ажиллагааны улсын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн тайланг ирүүлэх тухай ЦЭК-ын Ажлын албаны 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/745 дугаартай албан бичгийг цацрагийн ослоос хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн захиргааны 11 байгууллагуудад хүргүүлсэн. - Монгол Улсын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний төсөлд оруулсан Цацрагийн ослын үед ажиллах төлөвлөгөөний төсөлд оруулах саналыг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 1/254 дугаартай албан бичгээр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хүргүүлсэн. - Монгол Улсын Гамшгаас хамгаалах улсын алба, улсын албаны дарга, тэдгээрийг түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллагын жагсаалт, чиг үүрэг, Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-ын төсөлд тусгах саналыг 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 1/514 дугаартай албан бичгээр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хүргүүлсэн. - ЗХЖШ-ын ирүүлсэн хүсэлтийн дагуу Зэвсэгт хүчний цацраг хими, биологиос хамгаалахын офицеруудын цугларалтад Монгол Улсад ашиглагдаж байгаа сүүлийн үеийн цацрагийн хэмжилтийн багаж болон хэмжилт хэрхэн хийдэг талаар танилцуулга хийсэн.	100

						- ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадтай хамтран 08 дугаар сарын 29-ны өдөр “Цацрагийн ослоос хамгаалах үйл ажиллагааны улсын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангуулах, цацрагийн ослоос сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, ослын үед ажиллах мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор “Цацрагийн ослын үеийн хариу арга хэмжээ” сэдэвт хамтарсан дадлага, сургуулилтыг Үндэсний аврах бригадын Тахилт дахь сургалт дадлагын талбайд зохион байгуулсан. - ЦЭК-ын Ажлын албаны 2025 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөөлөлд “Цацрагийн болзошгүй ослын үед бэлэн байлгах шаардлагатай багаж тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгсэл материалын жагсаалт”-ыг шинэчлэн хүргүүлсэн. - ДЦС-уудаас ирүүлсэн ашиглаж буй нүүрс, хаягдал үнс, үнсэн сангийн лабораторийн шинжилгээний мэдээллүүдийг нэгтгэж, танилцуулга боловсруулж, ЦАЗ-д танилцуулсан. - БОУАӨЯ-ны Мэргэжлийн зөвлөлийн “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ”-ний тайлан хэлэлцэх хуралд нийт 12 удаа оролцож, 92 аж ахуйн, нэгж байгууллагын тайланг хэлэлцэж, Цөмийн энергийн тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартын хэрэгжилтийг хангуулж, зөвлөмж өгсөн. - “Оюу толгой” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус компанийн гүний уурхайн радоны хуримтлалын хэмжээг тодорхойлох, ажилтнуудыг цацрагийн дотоод шарлагын эрсдэлээс сэргийлэх зорилгоор 7 байршлын 55 цэгт нийт 55 ширхэг идэвхгүй радоны детектор байршуулах ажлын төлөвлөгөөг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01/320 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - “Монгол орны радоны эрсдэлт бүсийн зураглал боловсруулах нь” МОН9010 төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - Монгол Улсын 21 аймагт тараан байршуулсан нийт 1000 ширхэг идэвхгүй радоны детекторуудад хэмжилт хийж, радоны агууламжийг тодорхойлсон. - МОН9010 төслийн 2023 оны тайланг боловсруулж, ОУАЭА-т хүргүүлсэн. - МОН9010 төслийн хүрээнд ОУАЭА-аас нийлүүлсэн хөрс, ус, агаарт хэмжилт хийх зориулалттай 2 ширхэг RAD-8 загварын	
--	--	--	--	--	--	---	--

						идэвхтэй радон детекторын татвараас чөлөөлүүлэх ажлыг зохион байгуулж, хүлээн авсан.	
5.4.	Ашиглагдахгүй болсон цацраг идэвхт материалд хаягдлын менежмент хийх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардал	- Цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийн болгон сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт /хувиар/;	- Цацрагийн үүсгүүрийг түр хадгалалтад хүлээн авах, хүлээлгэн өгөх нийт 10 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулсан. - Цацрагийн үүсгүүрийн түр хадгалалтын гэрээ байгуулсан ААН байгууллагын төлбөрийн үлдэгдлийг барагдуулах ажлыг зохион байгуулж, 2023 онд 21,700,000 төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн. - Байгууламжийн цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа, биет хамгаалалтыг ханган ажилласан.	- Изотоп конторыг цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламж болгон сайжруулна. - Ашиглагдахгүй болсон цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт хаягдлыг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг зохион байгуулна. - Байгууламжийн цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажиллана.	- "ОУАЭА-ийн мэргэжилтнүүдтэй хамтран ашиглагдахгүй болсон цацраг идэвхт битүү үүсгүүрүүдийг ангилан ялгах, бүртгэл хийх тухай" ЦЭК-ын Ажлын албаны даргын 2024 оны А/47 дугаар тушаалын дагуу Изотоп конторт хадгалагдаж буй ашиглагдахгүй болсон цацраг идэвхт Ra-226 үүсгүүрийн судалгааг гаргаж, байршлыг тодорхойлсон. ОУАЭА-ийн 3 экспертүүдийн хамт нийт 52 ширхэг Ra-226 цацраг идэвхт үүсгүүрийг ангилан ялгаж, зохистой төлөвт шилжүүлэх ажлыг зохион байгуулсан. - ОУАЭА-ийн RAS9085 төслийн хүрээнд 101,390,846.20 (нэг зуун нэг сая гурван зуун ерэн мянга найман зуун дөхөн зургаан төгрөг хорин мөнгө) төгрөгийн үнэ бүхий цацраг идэвхт хаягдал хадгалах хар тугалган хамгаалалттай контейнер сав 2 ширхэг, цацраг идэвхт үүсгүүр хадгалах капсул 10 ширхэг, иж бүрэн багаж хэрэгслийг хүлээн авч Цөмийн энергийн комиссын Ажлын албаны даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/53 дугаартай тушаалаар үндсэн хөрөнгөд бүртгүүлсэн.Хаягдлын менежментийн 3 дугаар агуулах шинээр барих ажлын хүрээнд АНУ-ын ЭХЯ-ны Сандиагийн үндэсний лабораторийн хариуцсан албан хаагчтай цахимаар холбогдож, шинээр бариулах агуулахын ажлын даалгаврыг тохирсон. Ашиглагдахгүй болсон цацраг идэвхт үүсгүүр хадгалах 3 дугаар агуулах шинээр барих байршлын инженер геологийн судалгаа, дэвсгэр зургийгхийлгэх ажлыг зохион байгуулсан. - АНУ-ын Эрчим хүчний яамны Цацрагийн аюулгүй байдлын газар, Сандиагийн үндэсний лабораторийн холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран 2025 онд шинээр барих агуулахын цацрагийн хамгаалалтын тооцоолол болон агуулахын зураг төслийг “Воч Лайн” ХХК болон “Аксиом” зураг төслийн компанитай харилцан тохирсон. - Нийт 4 (“Масс Теч” ХХК, “Жи Пи Ти” ХХК, “Жи И энд Эс” ХХК, “Гео Инженеринг” ХХК) аж ахуйн нэгж байгууллагын 8 ширхэг цацрагийн үүсгүүрийг нийт 11 удаа Цөмийн болон цацрагийн улсын байцаагчийн хяналт дор акт, протокол үйлдэн Изотоп конторын түр хадгалалтад хүлээн авах, хүлээлгэн өгөх ажлыг хийж гүйцэтгэсэн.	100

5.5.	Ионжуулагч цацрагийн хэмжих хэрэгслийн нэгдмэл байдлыг хангах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардал	- MNS ISO/IEC:17025 стандартын хэрэгжилт /хувиар/; - Олон улсын хоёрдогч стандартын лабораторийн сүлжээнд нэгдэн орсон эсэх; - Тохируулга, баталгаажуулалт хийсэн хэмжих хэрэгсэл болон олгосон гэрчилгээний тоо; - Зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилт /хувиар/;	- 2023 онд 73 аж ахуй нэгж, байгууллагын 285 хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийж, баталгаажуулалтын гэрчилгээ олгосон. - Ажлын шаардлага хангаагүй, шалгалт баталгаажуулалт хийх боломжгүй 9 ширхэг хэмжих хэрэгсэлд мэдэгдэл олгосон. - ХАБҮЛЛ-ийн ЦХЛ-ийн 20 ширхэг хувийн тунгийн дозиметрийг Cs-137 үүсгүүрээр, хүсэлтийн дагуу 2 мЗв, 1 мЗв, 0.5 мЗв, 0.2 мЗв тунгуудаар шарж хүргүүлсэн. - Орчны ионжуулагч цацрагийг хэмжигч хамгаалалтын болон оношилгооны түвшний багаж хэрэгсэлд рентген цацрагийн нарийн спектрийн мужид баталгаажуулалт хийх аргачиллыг тус тус шинэчлэн боловсруулсан.	- Чанарын удирдлагын тогтолцоо, MNS ISO/IEC:17025 стандартын хэрэгжилтийг хангуулж, олон улсын дозиметрийн хоёрдогч стандартын лабораторийн сүлжээнд нэгдэн орох ажлыг зохион байгуулна. - Ионжуулагч цацрагийн хэмжих хэрэгсэл, дозиметрт тохируулга, баталгаажуулалт хийнэ. - Лабораторийн техникийн чадавх, орчин нөхцлийг сайжруулах арга хэмжээг зохион байгуулна.	- MNS ISO/IEC 17025:2018 – Сорилт, тохируулгын лаборатори” стандартын дагуу лабораторийн чанарын гарын авлагыг шинэчлэн боловсруулж, итгэмжлүүлэхтэй холбоотой өргөдөл, шаардлагатай бусад мэдээлэл, маягтуудыг Үндэсний итгэмжлэлийн газарт хүргүүлэхээр бэлтгэсэн. - Цацрагийн хэмжлийн төрлөөр улсын шалгагчийн эрх шинээр олгох сургалтын төлөвлөгөөг СХЗГ-ын Мэдээллийн технологи, стандартын лавлагаа, сургалтын төвөөр батлуулж, Цацрагийн хэмжлийн улсын шалгагчийн эрх олгох хөтөлбөрт ДТБЛ-ийн 1 ажилтан хамрагдаж, улсын шалгагчийн эрх авсан. - СХЗГ-аас боловсруулж буй “Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагад тавих ерөнхий шаардлага”, “Шалгалт тохируулгын ажилтны чадавхыг үнэлэхэд тавих шаардлага” зэрэг стандартын төслүүдэд санал өгсөн. - ОУАЭА/ДЭМБ-ын ХСДЛ-ийн сүлжээнд нэгдэн орохтой холбоотой хүсэлтийг хүргүүлэхээр шаардлагатай баримт бичгийг судалж, боловсруулсан. - Тайлангийн хугацаанд 88 аж ахуйн нэгж, байгууллагын 356 ширхэг хэмжих хэрэгслийг баталгаажуулахаар хүлээн авснаас 343 хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийж, баталгаажуулалтын гэрчилгээ олгосон. Ажлын шаардлага хангаагүй, шалгалт баталгаажуулалт хийх боломжгүй 13 ширхэг хэмжих хэрэгсэлд мэдэгдэл олгосон. - СХЗГ-ын ХАБҮЛЛ-ийн Цацрагийн хяналтын лабораторийн хүсэлтийн дагуу тус лабораториос ирүүлсэн 80 ширхэг хувийн тунгийн хэмжих хэрэгсэл (TLD)-ийг Cs-137 цацраг идэвхт үүсгүүр бүхий G10 шарлагын төхөөрөмжийг ашиглан 2 мЗв, 1 мЗв, 0.5 мЗв, 0.2 мЗв тунгуудаар шарж хүргүүлсэн. - MNS 5840:2008 “Орчны ионжуулагч цацрагийг хэмжигч багажийг дүйцүүлэн харьцуулах арга” Монгол Улсын үндэсний стандартыг MNS 5840:2024 “Хувийн болон орчны гамма цацрагийн тун, тунгийн чадал хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх аргачлал”-аар шинэчлэн боловсруулж, стандартын төсөлд санал авахаар 7 байгууллагад хүргүүлж санал авсан. Стандартын төслийг СХЗГ-ын Хэмжил зүйн стандартчиллын техникийн хорооны 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан.	90
------	---	------------------------	---	--	---	---	----

						- “Цөмийн болон цацрагийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа” төслийн хүрээнд цөмийн болон цацрагийн хяналтын тогтолцоонд нийт 119,380.00€ (нэг зуун арван есөн мянга гурван зуун наян евро)-ийн үнэ бүхий оптик цацаргалтын люминесценцийн дозиметрийн нэвтрүүлэх, автомат уншигч (OSLR50 Automatic Reader with InLight, eye, ring dosimeter) авах асуудлыг тус тус шийдвэрлэсэн. Тус төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах, лабораторийг менежментийн тогтолцоог бий болгож, үр дүнтэй менежментийн тогтолцоог тогтвортой авч явах зорилгоор хүний нөөцийг бэлтгэх ажлын хүрээнд 2 албан хаагчийг Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотод байрлах тоног төхөөрөмж үйлдвэрлэгчийн сургалтын төвд 2025 оны 2 дугаар сарын 3-28-ны өдрүүдэд хамруулах ажлыг шийдвэрлэсэн.	
Стратегийн зорилт 6. Хоёр болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх;							
6.1.	Гадаад улс, олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.	Үйл ажиллагааны зардал	- Гэрээ, санамж бичгийн хэрэгжилтийн хувь;	- ОУАЭА, АНДБХАХ, АЦХАФ, ЦШНИ зэрэг олон улсын байгууллага, ОХУ, АНУ, БНФУ, БНСУ, Япон зэрэг улстай хамтран төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна. - 2023 онд нийт 104 гадаад арга хэмжээ (хурал, уулзалт 40, сургалт 38, семинар 18, бага хурал 2, 1 дадлагажих сургалт 3, танилцах айлчлал 3, салбараар авч үзвэл Эрүүл мэнд-15, Хүнс, хөдөө аж ахуй-15, Боловсрол, хүний нөөц-5, Цөмийн дэд бүтэц, суурь судалгаа хөгжүүлэлт-2, Цөмийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа-31, Цөмийн эрчим хүч-13, Геологи, уул уурхай-1, Байгаль орчин-8, Удирдлага, зохицуулалт, менежмент-10, Аж үйлдвэр-4)-д 31	Цөмийн энергийн салбарт байгуулсан олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Олон улсын байгууллага болон бусад орны холбогдох байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллана.	Хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд: - Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, ТХА-ны Монгол, Оросын ЗГХК-ын XXVI хуралдаан 2024 оны 12 дугаар сард Москва хотод зохион байгуулагдахтай холбогдуулан Комиссын монголын талын үндэсний хэсгийн гишүүд, шинжээчидтэй хийсэн уулзалтад ЦЭК, МУИС-ийн ЦФСТ-ийн төлөөллийг оролцуулж, санамж бичгийн хэрэгжилтийн талаар мэдээлсэн. - ЦЭК, Франц Улсын Атомын энерги болон альтернатив эрчим хүчний комиссиарат, хоёр орны ЭСЯ хооронд 2022 онд байгуулсан “Үйл ажиллагааны 2022-2024 оны төлөвлөгөө”-ний хүрээнд ЦЭК, МУИС, ШУТИС, Франц Улсын цөмийн энергийн олон улсын институт, цөмийн энергийн хөтөлбөртэй 3 их сургуулийг оролцуулан цахим уулзалт хийсэн. “Үйл ажиллагааны 2022-2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлууд, санхүүжилтийн талаар Францын ЭСЯ-ны Эрчим хүчний асуудал хариуцсан мэргэжилтэнтэй цахим уулзалт хийсэн. - БНКАЗУ-ын Ерөнхийлөгч Монгол Улсад төрийн айлчлал хийх үеэр “Цөмийн энергийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Цөмийн энергийн комисс, Бүгд Найрамдах Казахстан Улсын Эрчим хүчний яам хоорондын санамж бичиг байгуулсан. - ЯАЭА-ийн Япон Улсад зохион байгуулдаг сургалтуудад 2024 онд “Сургагч багш бэлтгэх сургалт”-д гадаад орчны цацрагийн хяналтын чиглэлээр 1, ахисан түвшний сургалтад	100

				байгууллагын давхардсан тоогоор 151 албан хаагч, мэргэжилтнүүдийг хамруулсан.		реакторын инженерчлэлийн чиглэлээр 1, “Цөмийн технологийн семинар”-ын ЦЭХС-ын аюулгүй ажиллагааны семинарт 1, цөмийн энергийн салбарын албан хаагчдад зориулсан семинарт 1, нийт 4 албан хаагчийг оролцуулсан. ЯАЭА-тай хамтран Монгол Улсад жил бүр зохион байгуулдаг “Реакторын инженерчлэл” дагалдах сургалтад 10 байгууллагын 20, “Цөмийн болон цацрагийн ослын бэлэн байдал” дагалдах сургалтад 14 байгууллагын 21, “Гадаад орчны цацрагийн хяналт” сургалтад 16 байгууллагын 22 албан хаагч хамрагдсан. Японы талтай удирдах албан тушаалтны уулзалтыг 2024 оны 8 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулсан. - 2024 оны 9-р сард Австри Улсын Вена хотод болсон ОУАЭА-ийн Ерөнхий бага хурлын 68 дугаар чуулганы үеэр Ази, Номхон далайн бүсийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн Бүсийн төвтэй харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. - Япон улсын Жайка төслийн мэргэжилтнүүдтэй 2-р сард, БНСУ-ын ЭСЯ-ны 1, 2 дугаар нарийн бичгийн дарга нартай 5-р сард, ОХУ-ын ЭСЯ-тай 5-р сард, ОУАЭА-ийн Ерөнхий бага хурлын 68 дугаар чуулганы үеэр Узбекистаны “УзАтом” агентлагийн төлөөлөлтэй хоёр талын уулзалт хийж, үйл ажиллагаа, хамтран ажиллах боломжийн талаар мэдээлэл солилцсон.	
						Олон талт хамтын ажиллагааны хүрээнд: - ОУАЭА-ийн ТХА-ны хөтөлбөрийн 2026-2027 онд хэрэгжүүлэх үндэсний 4 төслийн “Country Programme Note”-г ОУАЭА-т илгээж, дэмжигдсэн. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд төслийн баримт бичгийг ОУАЭА-аас зөвлөмж авч боловсруулсан. Монгол Улс, ОУАЭА-ийн хооронд байгуулсан “Техникийн хамтын ажиллагааны хүрээ 2022-2027” баримт бичгийн хүрээнд хэрэгжиж буй MON0013, MON5026, MON6022, MON6023 үндэсний төслүүдээр 5 байгууллагын 9 албан хаагчийг танилцах айлчлал, дадлагажих сургалтад оролцуулсан. ОУАЭА-ийн бүсийн төслүүдийн 35 арга хэмжээнд 67 албан хаагчийг оролцуулсан. ОУАЭА-ийн бүс хоорондын төслүүдийн 14 арга хэмжээнд 17 албан хаагчийг оролцуулсан. ОУАЭА-аас зохион байгуулсан бусад 25 арга хэмжээнд 32 албан хаагчийг оролцуулсан. ОУАЭА-ийн Ерөнхий бага хурлын 68 дугаар чуулганы үеэр Цөмийн эрчим хүчний газар, Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааны	100

						газар, Техникийн хамтын ажиллагааны газар, “РАСТ” Хавдрын эмчилгээний үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөөлөгчидтэй хоёр талын уулзалт хийсэн. - АНДБХАХ-ийн бүсийн төслүүдийн 28 арга хэмжээнд 37 албан хаагчийг оролцуулсан. АНДБХАХ-ийн 2026-2027 оны циклд хэрэгжих бүсийн төслийн саналыг АНДБХАХ-ийн бүсийн төвд уламжилсан. - АЦХАФ-ын Удирдах албан тушаалтнуудын хурал, Үндэсний зохицуулагчдын 24 дүгээр хурал, Техникийн уулзалт, төслүүдийн уулзалтуудад 4 байгууллагын 10 албан хаагчийг оролцуулсан. АЦХАФ-ийн 5 төслийн саналыг үнэлсэн. АЦХАФ-ын “Мутаци үржүүлгийн төсөл”-ийн уулзалтыг Монгол Улсад төсөл хэрэгжүүлэгч байгууллага ХААИС-ийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэн зохион байгуулсан. АЦХАФ-ын “FNCA Awards” шагналд “Шилдэг эмэгтэй судлаач” төрөлд 1 судлаачийг нэр дэвшүүлсэн. - ЦШНИ-тэй хамтын ажиллагааг идэвхжүүлэхээр салбарын тэргүүлэх эрдэмтэд, эрдэм шинжилгээний байгууллагын удирдлагуудтай санал солилцох уулзалт, Монгол Улсад 2025 онд хамтарсан арга хэмжээ зохион байгуулах талаар ЦШНИ-тэй цахим уулзалт, ОУАЭА-ийн Ерөнхий бага хурлын 68 дугаар чуулганы үеэр ЦШНИ-ийн төлөөлөгчидтэй хоёр талын уулзалт зохион байгуулсан. Хоёр талын хамтын ажиллагааг зохицуулах, харилцан мэдээлэл солилцох байнгын ажлын хэсэг байгуулсан. МУИС-ийн ЦФСТ-д “ЦШНИ-ийн Мэдээллийн төв” байгуулах бэлтгэл ажлыг хангах чиглэлийг холбогдох байгууллагад өгсөн. - ОУАЭА-ийн 2025 оны гишүүнчлэлийн татвар 20,098 евро, 2,428 ам.доллар төлсөн. - Гадаад хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцогчдыг бүртгэлжүүлсэн. 2024 онд олон улсад зохион байгуулагдсан 121 арга хэмжээнд 31 байгууллагын давхардсан тоогоор 177 албан хаагч оролцсон байна. - ОУАЭА-ийн imРАСТ үнэлгээний баг, АНДБХАХ-ийн “Хүнс хөдөө аж ахуй, аж үйлдвэр, хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах салбарт электрон цацрагийн технологи, түүний хэрэглээг дэмжих нь” төслөөр АНУ-ын экспертүүд ирж ажиллах, “БЧМР-ын технологи ба Монгол Улсаас цөмийн эрчим хүчний талаар явуулж буй үйл ажиллагаа” вебинар, ОУАЭА-
--	--	--	--	--	--	---

						ийн RAS9096 бүсийн төслийн семинар, MON2010 үндэсний төслийн 3 үндэсний семинарыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан. - ОУАЭА-ийн Ерөнхий бага хурлын 68 дугаар чуулган, Ази, номхон далайн бүсийн гишүүн орнуудын Үндэсний зохицуулагчдын уулзалт, АНДБХАХ-ийн Үндэсний зохицуулагчдын 46 дугаар хурал, 53 дугаар Ерөнхий бага чуулган, АЦХАФ-ын Сайд нарын түвшний 25 дугаар хурал, Удирдах албан тушаалтны хурал, Үндэсний зохицуулагчдын 24 дүгээр хурал, Техникийн зөвлөгөөн, ЦШНИ-ийн Санхүүгийн хорооны хурал, гишүүн орнуудын Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгчдийн хорооны чуулгануудад төлөөлөгчдийг оролцуулсан.	
Стратегийн зорилт 7. Салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах;							
7.1.	Салбарын мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтийн цөмийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардал	- Олон нийтэд хүргэсэн арга хэмжээний хэрэгжилт /хувиар/;	- Байгууллагын цахим хуудсанд нийт 70 мэдээ, мэдээллийг байршуулсан. - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.2-т заасны дагуу өөрийн цахим хуудас болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд 8 мэдээлэл байршуулсан. - “Цөмийн нэгдсэн групп”-т цөмийн эрчим хүч, уран, цөмийн технологи, цөмийн аюулгүй байдал, цөмийн аюулгүй ажиллагаатай холбоотой 312 пост нийтэлж, давхардсан тоогоор 77323 хүний хандалт авсан.	Байгууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр салбарын үйл ажиллагааг сурталчлах, мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулна.	- Байгууллагын цахим хуудсанд 82, олон нийтийн цахим сүлжээнд 13 мэдээ, мэдээллийг байршуулсан. Үүнд: - Тэнгэр телевиз (Gej yu ve?)-ээс зохион байгуулсан SciCon2024 (Scientific Conference 2024) арга хэмжээнд дэмжигч байгууллагаар оролцож, 1500 орчим хүнд цөмийн технологи, ионжуулагч цацрагийн төрөл, шинж чанарын талаар үнэн зөв бодит мэдээлэл, ойлголт өгч, альфа, бета, гамма цацраг хэмжих хэрэгсэл, үүлэн камераар ураны хүдрийн цацрагийн мөрийг ажиглах туршилт, хэмжилтүүдийг хийж, “Цөмийн технологи”, “Ионжуулагч цацрагийн талаар мэдлэг олж авцгаая” сэтгүүлүүд болон Ажлын албаны номын хавчуургыг сонирхсон хүмүүсд өгч, цөмийн энергийн салбарыг үр дүнтэйгээр сурталчилсан. - ЗХЖШ-ын албан хаагчдад цөмийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин, олон улсын гэрээ конвенц, цөмийн зэвсгийн тухай мэдээлэл өгч, илтгэл танилцуулсан. - “БНХАУ-ын ногоон хөгжлийн сорилт, ололт ба Монголын боломж” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд “БНХАУ дахь Цөм эрчим хүчний хөгжүүлэлт ба Монгол Улс” сэдвээр, “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” уулзалт хэлэлцүүлэгт “Эрүүл мэндийн салбараас үүсэж буй цацраг идэвхт хаягдлын менежмент” сэдвээр, Улсын хоёрдугаар төв эмнэлэгээс зохион байгуулсан “Эмнэлгийн орчинд ашигладаг рентген цацрагийн ашиглалт түүний хамгаалалт” сэдэвт сургалтад “Цацрагийн хамгаалалт аюулгүй	100

					ажиллагааны дүрэм журам” сэдвээр, ЭХЯ, Цөмийн энергийн комиссоос ОУАЭА-тай хамтран зохион байгуулсан “Цөмийн эрчим хүчний станцын газар сонголт ба цахилгаан сүлжээ” сэдэвт үндэсний семинарт “Цөмийн энергийн салбарын эрх зүйн орчин” сэдвээр тус тус илтгэл тавьж, танилцуулсан. - Нийслэлийн ерөнхий боловсролын 2 дугаар сургууль болон “Оюуны ундраа цогцолбор” сургуулиас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сургуулиудын физик хичээлийг сонгон суралцаж байгаа сурагчид болон физикийн багш нарт “Ионжуулагч цацрагийн тухай ерөнхий ойлголт, Цөмийн технологийн хэрэглээ” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 2 дугаар сургуулийн 50 сурагч, “Оюуны ундраа цогцолбор” сургуулийн 120 гаруй багш, сурагчид хамрагдсан. - АШУИС-ийн НЭМС-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сургуулийн ХАБЭА-н хөтөлбөрийн 3 дугаар курсийн 60 оюутанд “Цөмийн технологи, цацрагийн хамгаалалт, ионжуулагч цацраг хэмжих хэрэгсэл” сэдвийн илтгэл тавьж, хэмжих хэрэгсэл ашиглах дадлага ажил орсон. - МУИС-ийн Шинжлэх ухаан, технологийн сургуулийн зохион байгуулсан “Байгалийн нөөцийн инженерчлэл ба тогтвортой хөгжил” сэдэвт үзэсгэлэн форумд цацрагийн талаар болон ионжуулагч цацраг хэмждэг багаж хэрэгслийг танилцуулан оролцсон. - Нийслэлийн ерөнхий боловсролын “Тэгш ухаан” сургуулиас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сургуулийн багш, сурагчдад “Ионжуулагч цацраг, цөмийн технологи” сэдвээр танилцуулга, хичээл орж, хэмжилтээр багажаар цацраг хэмжих, үүлэн камераар цацрагийн мөр ажиглах зэрэг дасгал ажлуудыг гүйцэтгэсэн. - Нийслэлийн ерөнхий боловсролын 1 дүгээр дунд сургуулиас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сургуулийн төгсөх ангийн сурагчдад мэргэжил сонголтыг байгалийн шинжлэх ухаан, инженер технологи руу чиглүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “Universum Sapientiam” арга хэмжээнд “Ионжуулагч цацраг, түүний хэрэглээ ба Цөмийн инженерчлэл хөтөлбөр” сэдвээр танилцуулга, хичээл орж, хэмжилтээр багажаар цацраг хэмжих, үүлэн камераар цацрагийн мөр ажиглах зэрэг дасгал ажлуудыг гүйцэтгэсэн. - Олон нийтэд зориулсан “Цөмийн эрчим хүчийг ашиглах асуудалд” өгүүлэл бичиж “Шинжлэх ухаан амьдрал” сэтгүүлд хэвлүүлсэн.	
--	--	--	--	--	---	--

						- МҮОНРТ-ийн Монголын мэдээ сувгийн ярилцлагын цаг нэвтрүүлэгт оролцож Монгол Улсад цөмийн эрчим хүчийг ашиглах төрийн бодлогыг хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгсөн. - ЭХЯ, ЦЭК, ШУА-аас хамтран зохион байгуулсан “Монголын эрчим хүчний систем ба цөмийн эрчим хүчийг ашиглах боломж” сэдэвт ЭШ-ний бага хуралд “Монгол Улсад цөмийн эрчим хүчийг ашиглах төрийн бодлогыг хэрэгжүүлэх арга зам”, УУХҮЯ, АМГТГ, ҮГА, ШУТИС, МУИС, ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн, Геологийн хүрээлэн, геологийн салбарын мэргэжлийн холбоод хамтран зохион байгуулсан “Монголын геологи, хайгуул 2024” чуулга уулзалтад “Цацраг идэвхт ашигт малтмалын өнөөгийн байдал” ерөнхий илтгэл, хөрөнгө оруулагчдын бизнес уулзалтад “Цацраг идэвхт ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэд оруулах нь” сэдвээр тус тус илтгэл тавьж, оролцсон.	
Стратегийн зорилт 8. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах;							
8.1.	Байгууллагын төрийн захиргааны удирдлага, зохицуулалтыг хангах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардал	- Тайлан мэдээг хүргүүлсэн эсэх; - Тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлсэн эсэх; - Тайлан төлөвлөгөөг батлуулсан эсэх; - Цахим системийг хөтөлсөн эсэх;	- ҮАБЗ-ийн танилцуулах тойм мэдээг 14, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 1, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг 1, Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг 1, гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн төслийн хэрэгжилтийг 1, бусад цаг үеийн холбогдолтой тайлан, мэдээг тухай бүрт нь хугацаанд нь хүргүүлсэн. - Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн тайланг https://plan.igovernment.mn/planorgan/ цахимаар тайлагнасан.	- Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна. - Гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулна. - Дотоод үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, гэрээ, зөвлөмж, заавар, аргачлал, төлөвлөгөө зэрэг баримт бичгийн төсөлд санал өгөх, шаардлагатай баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулна. - Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.	- ҮАБЗ-ийн 2023 оны 12 сарын болон сүүлийн хагас жилийн, 2024 оны эхний хагас жилийн болон 1-12 дугаар сарын танилцуулах тойм мэдээг тус тус хүргүүлсэн. - 2023 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт хүргүүлж, 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 07/1254 тоот албан бичгээр аудитын шийдвэр ирсэн. Аудитын зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөөг Үндэсний аудитын газарт 1/358 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - 2023 оны санхүүгийн тайланг БШУЯ-нд хүргүүлж, Сангийн яамны Э-тайлан цахим системд байршуулж, баталгаажуулсан. 1-11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, НД-ын тайлан, ХХОАТ-ын тайлан, шилэн дансны цахим сайтад 64 мэдээ мэдээлэл, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэх маягт зэрэг санхүү, аж ахуйтай холбоотой тайлан мэдээг холбогдох байгууллагад тус тус хугацаанд нь хүргүүлж баталгаажуулсан. - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн 2023 оны тайланг БШУЯ-нд цахим шуудангаар хүргүүлсэн. - Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын байдлаар гарган БШУЯ-ны цахим системд тайлагнасан. - Байгууллагын сул орон тооны талаарх мэдээлэл болон сул орон тоог нөхөхөд тулгардаг асуудлын талаар танилцуулга мэдээлэл боловсруулж АТГ-т цахимаар хүргүүлсэн.	100

						- Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг комиссын дарга, Ажлын албаны даргаар батлуулсан. - БШУ-ны сайд, комиссын дарга Л.Энх-Амгалан, ЦЭК-ын Ажлын албаны дарга Г.Манлайжавтай байгуулсан 2024 оны үр дүнгийн гэрээг батлуулсан. - Байгууллага, нэгж, албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан боловсруулах ажлыг шинээр батлагдсан тогтоол шийдвэр, аргачлалын дагуу зохион байгуулсан. 2024 оны эхний хагас жилд 27, жилийн эцсийн байдлаар нийт 33 албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан боловсруулж батлуулсан. - Байгууллагын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг БШУЯ-ны цахим системд тайлагнаж, Ажлын албаны даргын 2024 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлүүлэх ажлыг зохион байгуулсан. - Хөдөлмөрийн дотоод журмыг албан хаагчдаас санал авч шинэчлэн боловсруулж, удирдлагын зөвлөлд танилцуулж, Ажлын албаны даргын А/16 дугаар тушаалаар баталсан. - “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан байгууллагын Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, Ажлын албаны даргын А/04 дүгээр тушаалаар баталсан. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Ёс зүйн дэд хорооны мэдээллийг ТА3-д цахимаар хүргүүлсэн. - Байгууллагын Авилгын эсрэг үндэсний хөтөлбөрийн 2023 оны биелэлт, 2024 оны авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, АТГ-т хүргүүлсэн. Мөн албан хаагчдын ХАСХОМ-ийг бүртгэн авч, холбогдох тайлан мэдээг хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.	
8.2.	Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангана.	Үйл ажиллагааны зардал	- Хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн эсэх; - Төлөвлөгөөний хэрэгжилт /хувиар/; - Зарцуулсан төсөв;	- Төрийн захиргааны албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчлэн боловсруулж Ажлын албаны даргын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлуулсан. - Байгууллагын нийт албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалин шинэчлэн тогтоох тухай 29 тушаал	- Албан хаагчдыг томилох, чөлөөлөх, албан тушаал дэвшүүлэх, цол, зэрэг дэв олгох, цалин хөлсийг өөрчлөх, шагнаж урамшуулах, албан тушаал бууруулах, хариуцлага тооцох зэрэг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.	- Бүтэц, орон тоог шинэчлэн боловсруулж Ажлын албаны даргын 2024 оны А/63 дугаар тушаалаар баталсан. - Тайлангийн хугацаанд ТА3-өөс баталсан шалгалтын комисс байгуулах тухай шийдвэрийн дагуу 4 удаа тусгай шалгалт зохион байгуулж, ТА3-ийн хуралдаанд тайланг танилцуулж батлуулсан. - Албан хаагчдын 2023 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээний дүнг үндэслэн Ажлын албаны даргын 2024 оны А/15	100

				боловсруулж, батлуулсан. - ТА3-ийн хүний нөөцийн цахим систем дэх албан хаагчдын мэдээллийг тухай шинэчлэн хөтөлсөн. - Төрийн захиргааны 7, төрийн үйлчилгээний 3 албан тушаалын тодорхойлолтыг тус тус шинэчлэн боловсруулсан. - Төрийн захиргааны 7 албан тушаалын тодорхойлолтыг ТА3-ийн 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, ТА3-ийн 2023 оны 388 дугаар тогтоолоор батлах зөвшөөрөл авсан. - ТА3-ийн даргын 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 159 дүгээр тушаалаар тусгай шалгалт зохион байгуулсан.	- Албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулна. - Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулна.	дугаар тушаалаар 8 албан хаагчдад зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон. - Удирдах албан тушаалтнуудад зэрэг дэв олгуулахаар танилцуулга, мэдээллийг ТА3-д хүргүүлсэн. - Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан нийт 26 албан хаагчийн цалинг шинэчлэн Ажлын албаны даргын тушаалаар баталсан. - Албан хаагчдын албан тушаалаас чөлөөлөгдсөн, шинээр томилогдсон, цалин, зэрэг дэв өөрчлөгдсөн болон шагнал урамшууллын мэдээллийг ТА3-ийн хүний нөөцийн цахим системд бүртгэж, хувийн хэргийн баяжилтыг тухай бүр хийсэн. - Албан хаагчдыг чөлөөлөх, томилох, цалинг шинэчлэх, чөлөө олгох зэрэг нийт 134 тушаал баталсан. - Төрийн албаны ерөнхий шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн цөмийн технологи, цөмийн физик, цөмийн инженерчлэл, хими, физик, эрчим хүчний мэргэжилтэй иргэдийн жагсаалтыг Төрийн албаны зөвлөлд хүсэлт мэдээллийг гаргуулан авсан. - Цөмийн энергийн салбарын хүний нөөцийн судалгаа гаргахаар нийт 74 байгууллагад албан бичиг хүргүүлж, 56 байгууллага судалгаанд хамрагдаж хариу ирүүлсэн. - Сургалтын төлөвлөгөөнд албан хаагчдаас санал авч, Ажлын албаны даргын А/09 дүгээр тушаалаар баталсан. - Удирдлагын академийн мэргэшүүлэх болон дунд хугацааны, ахлах болон эрхэлсэн түшмэлийн, чиглүүлэх богино хугацааны сургалтуудад 13 албан хаагчийг хамруулсан. - ТА3-өөс зохион байгуулж буй 7:4:10 цахим сургалт болон байгууллагын дотоод сургалтыг 30 гаруй удаа зохион байгуулсан. - Улсын хэмжээнд зохион байгуулсан “Үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаанд албан хаагчдыг хамруулсан. - ТЗ-ны 4 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Ажлын албаны даргын 2024 оны А/03, ТҮ-ний 6 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Ажлын албаны даргын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/59 дүгээр тушаалаар тус тус баталсан. - 2024 оны Нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, ээлжийн амралтын хуваарийг албан хаагчдаас
--	--	--	--	--	---	--

						санал авч баталсан. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд албан хаагчдын дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан. - Сар шинийн баярыг тохиолдуулан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулсан.	
8.3.	Санхүү, аж ахуйн үйл ажиллагааг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардал	- Төсвийн гүйцэтгэл /хувиар/; - Тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлсэн эсэх; - Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан эсэх; - Цахим системийг хугацаанд нь хөтөлсөн эсэх;	- 2023 онд улсын төсвийн санхүүжилт 1,412,778.6 мянган төгрөгийг авч, 1,392,997.2 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан. Үндсэн үйл ажиллагаанаас 42,491.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн. - Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах байр ашиглалт болон хангамж бараа материалын зардалтай холбоотой 2 байгууллагатай гэрээ байгуулж, 7 байгууллагын гэрээ сунгаж, сар бүрийн төсөвт багтаан төлбөрийг төрийн сангаар дамжуулан зохион байгуулсан.	- Батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэх ажлыг зохион байгуулна. - Эд хөрөнгийг бүртгэх, акталж, данс бүртгэлээс хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд зохион байгуулна. - Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна.	- Байгууллагын 2025 оны төсвийн хязгаарын санал, 2026-2027 оны төсвийн төсөөлөлд нэгж, албан хаагчдаас санал авч, 1/537 дугаартай албан бичгээр БШУЯ-нд хүргүүлсэн. - Төсвийн хөрөнгө оруулалтын саналыг 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 1/508 тоот албан бичгээр АҮЭБЯ-нд хүргүүлсэн. - 2024 оны 1-11 дүгээр сарын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлан мэдээг БШУЯ, АҮЭБЯ-нд хүргүүлсэн. - Өмч хамгаалах зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, 6 асуудлыг хэлэлцүүлэн, хурлын тэмдэглэл хөтлөн, баталгаажуулж ахлах нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн. - 2024 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогын ажлыг зохион байгуулж, дүнг нэгтгэн, ахлах нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн. - Тооллого явуулах тухай Ажлын албаны даргын А/30, А/69 дүгээр тушаалыг тус тус баталсан. - Няравын ажлыг актаар хүлээлцэх ажлыг зохион байгуулж, албажуулсан. - Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 155,828.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий авто тээврийн хэрэгсэл, 86,224.8 мянган төгрөгийн дансны үнэ бүхий тавилга, эд хогшил, 25,759.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий программ хангамжийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгэх, шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлсэн. - “Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” ТӨБЗГ-ын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 524 дүгээр тогтоолын дагуу үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 78 нэр төрлийн 210,068,881.20 төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт 133,234,470.60 төгрөгөөр шинэчлэн тогтоож бүртгэсэн. - Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 27,5 сая төгрөгийн үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий Соната-6 маркын 00-73УНБ дугаартай 1ш автомашиныг актлуулах саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, ТӨБЗГ-ын 2024 оны	100

					532 дугаар тогтоолоор нээлттэй дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн. - Ажлын албаны даргын 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/08, А/29, А/53 дугаар тушаалын дагуу 221,987,834.40 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн. - БШУЯ-наас ирсэн 8 суурин, 3 зөөврийн компьютер, 2 принтерийг хүлээн авч, үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн. - Байгууллагын хэмжээнд 4 компьютерыг акталсан компьютерын хуучин эд ангиар сэлбэж засварласан. 6 компьютерын программын гэмтлийг засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан. 1 компьютерийг сэлбэж шинээр томилогдсон албан хаагчид суурилуулж өгсөн. - ОУАЭА-ийн ТХА-ны хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусламжаар хүлээн авсан Цөмийн цацрагийн мөрийн зураг авах танхимын сургалтанд ашиглах 8 ширхэг 11,384,808.20 төгрөгийн үнэ бүхий Хуурай мөсөн хөргөлттэй үүлэн камер, Цахилгаан хөргөлттэй үүлэн камер цацраг хэмжих багаж, туслах хэрэгсэлүүдийг үндсэн хөрөнгөд бүртгэж авсан. <u>Орлого /нийт/:</u> - 27 нэр төрлийн 93 ширхэг 411,317 төгрөгийн үнэ бүхий аж ахуйн бараа материал, 7 нэр төрлийн 1035 ширхэг 824,500 төгрөгийн бичиг хэргийн материал, 8 ширхэг 176,000 төгрөгийн БҮТЭЗ, 300,000 төгрөгийн үнэ бүхий шатахуун орлогод бүртгэсэн. <u>Зарлага /нийт/:</u> - 93 ширхэг 411,317 төгрөгийн аж ахуйн материал, 8 ширхэг 176,000 төгрөгийн БҮТЭЗ, 1035 ширхэг 824,500 төгрөгийн үнэ бүхий бараа материал, 300,000 төгрөгийн үнэ бүхий шатахууныг зарлагыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу баримт бичгийг бүрдүүлэн санхүүгийн программд бүртгэсэн. - Оффисын байрыг ус дулаанаар тогтвортой хангах ажлыг зохион байгуулж, сантехникийн шугам сүлжээний засвар үйлчилгээг тухай бүр хийх, радиатор, холбогч хэрэгсэл солих, бохирын шугам хоолойг шилжүүлэн холбох, газар шорооны ажил хийх зэрэг зайлшгүй шаардлагатай ажлуудыг гүйцэтгүүлэхээр мэргэжлийн 4 байгууллагаас санал авч, шаардагдах зардлыг шийдвэрлэн өгөх тухай хүсэлтийг 2024.09.10-ны өдрийн 1/527 дугаартай албан бичгээр АҮЭБЯ-нд хүргүүлсэн.. - 2024 онд худалдан авах ажиллагаанд 22,3 сая төгрөг тусгагдсан ба радон детектор, 350 ширхэг
--	--	--	--	--	--

						идэвхгүй радон детекторыг худалдах, худалдан авах гэрээг "Голден-Хоул" ХХК-тай байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. - Байрны цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалтын чиг үүргийг гэрээний дагуу зохион байгуулан ажиллаж байна.	
8.4.	Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, архив, албан хэрэг хөтлөлтийг хөтлөнө.	Үйл ажиллагааны зардал	- Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан эсэх; - Хууль тогтоомжийн хэрэгжилт /хувиар/; - Албан хэрэг хөтлөлтийн цахим системийг хөтөлсөн эсэх;	- Zoom онлайн хурлын программын эрх сунгалт хийж 6 уулзалт, хурал, сургалтыг зохион байгуулсан. - Албан ёсны эрхтэй вирусийн программыг нийт 27 компьютер, тоног төхөөрөмжинд суурилуулсан. - Вирусийн 54 программ худалдан авах ажлыг зохион байгуулсан.	- Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулна. - Архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна.	- Windows10, Windows11-ийн 4, Windows серверийн 1, нийт 5 эрхийг нэвтрүүлэн ашиглаж байна. Антивирусны 21 эрхийг сунгаж хэвийн ажиллагааг хангасан. - Байгууллагын дотоод сүлжээ, камерын хэвийн ажиллагаанд хяналт тавьж холбогдох албан тушаалтнуудыг мэдээллээр хангасан. - Дотоод удирдлагын Эйбл системийн хэвийн ажиллагааг хангаж, программд гарсан алдааг Эйбл компанитай хамтран шийдвэрлэсэн. Шинэ цаг бүртгэлийн төхөөрөмж суурилуулж 22 албан хаагчийн бүртгэлийг нүүр таних системээр бүртгэж сервертэй холболт хийж хэвийн ажиллагаанд оруулсан. Веб сервер дээр гарсан алдааг Үндэсний Дататөвтэй холбогдож шийдвэрлэсэн. - Цахим шуудангийн ашиглалтад хяналт тавьж нууц үг сэргээх ажлыг цаг тухай бүр хийж гүйцэтгэсэн. - Досх албан бичиг солилцооны дундын системд хяналт тавьж ажилласан. - Байгууллагын хэмжээнд цахим гарын үсэг хэрэглэх эрхтэй 4, нээлттэй өгөгдөл оруулах 1 албан хаагчид цахим гарын үсэг ашиглах гэрээг "Монпасс СА" тоон гарын үсгийн гэрчилгээ олгох байгууллагатай байгуулж, Е-Токен төхөөрөмжийг хүлээн авсан. - Тайлангийн хугацаанд дараах баримт бичгүүдийг цахим системд бүртгэж, цахим архивын файл үүсгэн хадгалсан. o ЦЭК-ын тэмдэглэл - 2 o ЦЭК-ын хуралдааны тэмдэглэлээс - 1 o ЦЭК-ын тогтоол - 3 o ЦЭК-ын албан бичиг - 8 o Ирсэн бичиг - 1223 o Явсан бичиг - 730 o А тушаал - 66 o Б тушаал - 68 o Гэрээ - 54 o Төлөвлөгөө - 5 o Тангараг өргөх ёслол - 6 o Албан даалгавар - 1 o Өргөдөл, гомдол - 43 - Байгууллагын архивт 10 бүртгэлийн дэвтэр хөтлөн ашиглаж байна. Тушаал, албан бичгийн	100

						хэвлэмэл хуудсыг АЕГ-т захиалан ашиглаж байна. - Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын дагуу байгууллагын тамга, тэмдгийг актаар хүлээлцэх ажлыг зохион байгуулан, тамга, тэмдэг, дардас, лацны ашиглалтад хяналт тавьж, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. - 2023 оны ХХНЖ-ын дагуу нэгж, албан хаагчдаас баримт бичиг хүлээн авах хуваарийн дагуу 83 хадгаламжийн нэгжийг байгууллагын архивт, актаар хүлээн авсан. - Нууц баримт бичгийг бүртгэлийн дагуу бүртгэж албан хаагчдад танилцуулсан. Шинээр томилогдсон албан хаагчдаар нууцын баталгаа гаргуулж, төрийн болон албаны нууцтай холбоотой хууль тогтоомж, дүрэм журмыг танилцуулсан. 2023 онд нууц баримт бичгийн хадгалалт, хамгаалалтын талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг ТЕГ-т хүргүүлсэн. - ЦЕГ-аас зохион байгуулсан команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг ханган, холбогдох албан хаагчдыг сургалтад оролцуулсан.	
8.5.	Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардал	- Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт /хувиар/; - Тайлан төлөвлөгөөг батлуулсан эсэх; - Цахим системийг хөтөлсөн эсэх; - Үнэлгээний багийг байгуулсан эсэх; - Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг холбогдох дүрэм журмын хүрээнд үнэлсэн эсэх;	- Албан хаагчдын гүйцэтгэлийн тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөг албажуулж, хувийг албан хаагчдад өгч, хувийн хэрэгт хийсэн - Зохион байгуулалтын нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, ажлыг зохион байгуулж, батлуулсан. - Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулж нийт 29 албан хаагчийн төлөвлөгөөг батлуулан, баталгаажуулж, албан хаагчдад хүргэсэн. - Байгууллага, нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг боловсруулах ажлыг	- Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, байгууллагын хэмжээнд дотоод хяналт хийх ажлыг зохион байгуулна. - Байгууллага, нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийн тайланд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулна.	- Гадаадын зээл тусламжаар 2023 онд хэрэгжсэн 4 төслийн тайланд ХШҮ хийж, 1/128 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. - Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд ХШҮ хийж, БШУЯ-ны цахим системд тайлагнасан. - Албан хаагчдын гадаадад томилолтоор ажилласан тухай илтгэх хуудас, цаг бүртгэл, автомашины бэлэн бусад торгуульд хяналт тавьсан. - 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг үнэлэх үнэлгээний хуудасны загварыг шинэчлэн боловсруулж, үнэлэх аргачлалыг үнэлгээний багийн ахлагч, гишүүд, нийт албан хаагчдад хүргэсэн. - Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийн хурлыг зохион байгуулан, үнэлэх ажлыг зохион байгуулж, 2024 оны хагас жилийн үнэлгээний хуудсыг баталгаажуулан албан хаагчдад цахимаар хүргүүлсэн. - Байгууллагын соёлын болон дотоод үйл ажиллагааны талаарх судалгааг нийт албан хаагчдаас авсан.	100

				зохион байгуулж, байгууллагын тайланг БШУЯ-ны цахим системд хугацаанд нь тайлагнасан. - Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг зохион байгуулсан.		- Байгууллагын эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг боловсруулж, ХШҮ хийж, БШУЯ-ны https://plan.igovernment.mn цахим системд тайлагнасан.	
--	--	--	--	--	--	---	--

xxxXXXXxxx